

2015 оны Хуваалцах цагийн тойм

Аврагч минь амьдыг би мэднэ

“Миний Золигч амьд гэдгийг болон эцэст Тэрээр дэлхий дээр байр сууриа эзэлнэ гэдгийг би мэднэ” (Иов 19:25).





Хуваалцах цаг болон Ариун ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгын зааварчилгаа

Хүндэт Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн болон Хөгжмийн удирдаачид аа,

Энэ жил та бүхэнд Аврагч Есүс Христийн, хүүхдийг хайрлах агуу хайрыг мэдэрч, ойлгон ухаарахад нь хүүхдүүдэд туслах боломж тохиолоо. Хүүхдүүд Ариун Сүнсний гэрчлэлээр дамжуулан Тэнгэрлэг Эцэгийн маань төлөвлөгөөний цөм нь Есүс Христ бөгөөд Түүнд итгэх итгэлийн талаар суралцах болно. Мөн тушаалуудыг сахиж, үйлчилж, сайн мэдээг хуваалцаж, Аврагчийн үлгэр дуурайлыг дагаснаар итгэл нь өсөж хүчирхэгжих нь Түүний Хоёр дахь ирэлтэд бэлтгэнэ гэдгийг сурна.

Та бүхний итгэлтэй, шаргуу үйлчлэлд талархъя. Бид та бүхний төлөө залбирдаг мөн хүүхдүүдийг хайрлаж, тэдэнд Есүс Христийн сайн мэдээг заах болон тэднийг сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахад нь тусалдаг чадварт тань найддаг билээ.

Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

Зөвлөмж:

Хүүхдүүдийг судруудаас суралцахад урьснаар насан туршидаа Бурханы үгийг хайрлах хайраа хөгжүүлэхэд нь тустай. Долоо хоног тутам судраа ашиглаж сурах боломж олгох арга замуудыг төлөвлө. Зарим нь сударгүй байж магадгүй. Зарим нь уншиж сураагүй байж болох юм. Энэ товхимлын 7, 12, 18-р хуудас дахь заахад зориулсан зөвлөмжүүд нь танд судруудыг ашиглан хэрхэн заах талаар тусламж үзүүлнэ.

Хуваалцах цагт зориулсан зааварчилгаа

Сайн мэдээний зааварчилгаа

Долоо хоног тутам хуваалцах цагийн 15 минутын хичээлийг бэлтгэхдээ энэхүү товхимлыг ашиглана уу. Сүмээс зөвшөөрөгдсөн *Найз* эсвэл *Лиакхона сэтгүүлээс ашиглаж болно*. Дараах удирдамжууд хичээлээ төлөвлөж заахад тань тусална.

Зааж буй хүүхдүүдээ хайрла. Хүүхдүүдийн сонирхол, авьяас билиг, хэрэгцээ шаардлагыг мөн тэдний нэрийг нь мэддэг болсноор тэднийг хайрлаж буйгаа харуул.

Сургаалыг Сүнсээр заа. Хичээлээ бэлтгэх явцдаа заах гэж буй зарчмуудынхаа талаарх гэрчлэлээ бэхжүүлж, удирдамж хүлээн авахын төлөө залбир. Энэ нь таныг Сүнсээр заахад туслах болно.

Хичээнгүй суралцахыг хүс. Энэхүү товхимол нь танд зөвхөн юу заахыг хэлээд зогсохгүй хэрхэн зааж, хүүхдүүдийг хичээнгүй суралцаг болгоход тусалж чадна. Та хичээл бүрдээ дараах гурван зүйлийг хэрэгжүүлснээр сургаалыг илүү үр дүнтэй заах болно.

- 1. Сургаалыг таньж мэд.** Хүүхдүүдэд сурах сургаалыг нь ойлгомжтой танилцуул. Үүнийг хэл яриагаараа болон үзүүлэн ашиглаж ойлгуул. (Жишээ болгож гурав болон долдугаар сарын эхний долоо хоногийн хичээлийг үзнэ үү.)
- 2. Ойлголтыг чухалчил.** Дуулах, жүжигчилсэн тоглолт үзүүлэх, судруудаас унших

зэрэг олон янзын арга хэлбэрээр заах нь тэдэнд сургаалыг гүн гүнзгий ойлгоход нь тусалдаг тул үүнийг чухалчилж авч үз.

3. Хэрэгжүүлэхийг чухалчил.

Хүүхдүүдэд сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэх боломж олго. Тухайн сургаалын талаар юу мэдэрснээ ярилцаж, хэрхэн зорилго тавих талаар туршлагаа хуваалц.

Энэ товхимолд энэ жилийн зарим долоо хоногт заагдах хичээлийг бүрэн эхээр нь багтаасан. Бусад долоо хоногийн хичээлүүдийг бүрнээр нь бус харин санаануудыг нь оруулж өгсөн ба шинэ санаанууд дээр өөрийнхөө санааг нэмж баяжуулан ашиглаарай. Та энэхүү товхимолд багтсан зарим хичээлүүдийг уншиж судлан санаа авах боломжтой. Тав дахь ням гарагт өмнөх үзсэн хичээлүүдээ давтаж, сэргээн зааж болно. Хичээлээ төлөвлөж бэлтгэх үед чинь Сүнс таныг удирдан хөтөлнө.

Хичээлээ хөгжмийн удирдаачтай хамтран бэлтгэ. Дуу дуулах нь таны зааж буй сургаалыг тодотгож батжуулахад тусална. Сайн мэдээний зарчмын зааварчилгааг заах үедээ та өөр ангийн багш, хүүхдүүдийг хичээлд оролцуулахаар урьж болно.

Зарим хичээл нь үг хэлэх зочин урихыг санал болгодог. Гэхдээ хэн нэгнийг урихаасаа өмнө бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө зөвшөөрөл авах хэрэгтэй.

Хичээлүүдэд заах ур чадвараа сайжруулахад тань туслах хэд хэдэн зөвлөмж багтсан байгаа. Тухайн хичээлд холбогдолтой зургуудыг мөн багтаасан болно. Хэдийгээр заах ур чадвар чухал ч таны сүнсэлэг бэлтгэл, гэрчлэл нь хүүхдүүдийн зүрх сэтгэлд сургаалуудыг бататгаж өгөх Сүнсийг урьдаг билээ.

Дууны цаг

Хүүхдийн хэсэгт дуу дуулах нь хүндэтгэлтэй намуухан орчинг бий болгож, сайн мэдээг зааж, Ариун Сүнс болон дуугаар ирдэг баяр баяслыг мэдрэхэд нь тусалдаг юм. Хуваалцах

цагийнхаа 20 минутыг дуу хөгжимд зарцуулах нь зүйтэй. Энэ хугацаа нь хүүхдүүд шинэ дуу сурах болон дуулахын сайхныг мэдрэхэд хангалттай цаг юм.

Энэхүү товхимолд хүүхдүүдийн энэ жил сурах ёстой шинэ дуунууд багтсан (28–29-р хуудсыг үз). Түүнчлэн “Хүүхдийн хэсэгт дуу хөгжмийг хэрхэн ашиглах тухай” гэсэн сэдэвтэй хэсгийг оруулж өгсөн (26–27-р хуудсыг үз) мөн дуунуудыг хүүхдүүдэд заах нэмэлт санаануудыг багтаасан (3, 5, 9, 15-ыг үз).



Ариун ёслолын цуглаан дээр хийх танилцуулгын хөтөлбөрт зориулсан удирдамж

Ариун ёслолын цуглаан дээр хүүхдүүдийн хийх танилцуулгыг жил бүрийн дөрөвдүгээр улиралд бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн удирдлаган дор хийдэг. Тухайн жилийн эхээр бишопын зөвлөл эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн Хүүхдийн хэсгийг хариуцсан зөвлөлтэй уулзаж, урьдчилсан төлөвлөгөөнийхөө талаар ярилцах хэрэгтэй. Төлөвлөж дууссаны дараа түүний зөвшөөрлийг ав.

Хүүхдүүд хөтөлбөрийг удирдан явуулах төлөвлөгөө нь сар тутмын хуваалцах цагийн сэдвүүдэд тулгуурласан байх хэрэгтэй. Жилийн туршид хүүхдүүдийн хэлсэн үг

болон хувийн туршлагаудыг тэмдэглэн авч танилцуулгын хөтөлбөрт ашиглах хэрэгтэй. Хүүхдүүдийн жилийн тайлан хөтөлбөрийг төлөвлөхдөө тэдний зааж байгаа сайн мэдээний сургаалд цуглаарагсдыг анхаарлаа хандуулах арга замыг бодоорой.

Танилцуулгыг бэлтгэх явцдаа дараах удирдамжийг дага:

- Танилцуулгын бэлтгэлийг хичээлийн болон гэр бүлтэйгээ өнгөрүүлэх цагаас нь авахгүй байхаар төлөвлө.
- Үзүүлэн, баг өмсгөл мөн телевиз эсвэл иймэрхүү төрлийн танилцуулгуудыг Ариун ёслолд ашиглах нь зохисгүй.



Зөвлөмж: *Та будах хуудас, түүхүүд болон үйл ажиллагаа зэрэг заахад тустай нэмэлт материал, эх сурвалжуудыг Найз болон Лиэхона сэтгүүлээс авах боломжтой. Эдгээр эх сурвалжийг ашиглан хичээлээ баяжуулан дэлгэрүүл.*



Ариун ёслолын цуглаан дээр хийх танилцуулга

Хүүхэд бүрээр бичиж бэлтгэсэн үг хэлүүлэх шаардлагагүй. Сайн танилцуулга нь олон янзын арга замаар хүүхдүүдийг хамруулдаг.

Энэхүү товхимолд ашиглагдсан эх сурвалжууд

Тус товхимолд дараах товчлолуудыг хэрэглэсэн:

ХДН *Хүүхдийн дууны ном*

TNGC *Teaching, No Greater Call*

Хичээлд зургууд ашиглахыг зөвлөсөн байгаа. Та зургуудыг *Сайн Мэдээний уран зургийн ном*, Сайн Мэдээний уран зургийн цуглуулга, Хүүхдийн хэсгийн гарын авлагын зургийн цомгууд, Сүмийн сэтгүүлүүд болон интернэт дэх images.lds.org хаягаар орж авч болно.

2015 оны сургалтын хөтөлбөр

Ерөнхий хөтөлбөр

Балчир хүүхдийн анги: *Бяцхан үрсээ болгоогтун*; Нарны цацраг: *Хүүхдийн хэсэг 1*; ЗС 4–7: *Хүүхдийн хэсэг 3*; Баатрууд 8–11: *Хүүхдийн хэсэг 6*

Үндсэн сургалтын хөтөлбөр

Нарны цацраг: *Хүүхдийн хэсэг 1*; ЗС 4–7: *Хүүхдийн хэсэг 3*; Баатрууд 8–11: *Хүүхдийн хэсэг 4*

Бид Бурхан, Мөнхийн Эцэг болон Түүний Хүү, Есүс Христэд итгэдэг.

Дуу: “Аврагч надад хайртайг мэднэ”
(Friend, 2002 оны 10-р сар, 46–47 эсвэл энэ тоймын 28–29-р хуудас)

Зөвлөмж: Хуваалцах цагаа заах бэлтгэлээ хийхдээ удирдамж болоод Сүнсний нөлөөллийг эрэлхийлэн залбир. Та Сүнсний нөлөөлөлтэйгээр бэлтгэж мөн заахад Сүнс таны зааж буй зүйлсийн үнэнийг батлах болно.

Зөвлөмж: Хүүхдүүдийг сургаалыг таньж мэдэхэд болон ойлгоход мөн үүнийгээ амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. Хүүхдүүдэд дараах боломжуудыг олгох талаар бодож үз:

- Сургаалын талаар ярилц.
- Сургаалтай холбоотой судруудын хэсгүүдээс унш.
- Сургаалыг дүрслэн үзүүл.
- Сургаалтай холбогдолтой дуу дуул.
- Сургаалтай холбоотой биеэрээ хийж болох үйл хөдлөл хий.

“Бурхан, Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ болон Ариун Сүнсэнд бид итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:1).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би тэдэнд Ариун Сүнсийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

1 дэх долоо хоног: Бурхан бол миний сүнсний Эцэг мөн

Сургаалыг таньж мэд: Хүүхдүүдэд олон янзын бээлий үзүүлээд өөр хоорондоо ялгаатай харагддаг шиг бид ч өөр хоорондоо ялгаатай болохыг тайлбарла. Бид хоорондоо ялгаатай харагддаг ч бид бүгдийн бие махбодын дотор амьдрал олгодог сүнс адилхан оршдог гэдгийг тайлбарла. Үүнийг дүрслэн үзүүлэхийн тулд бээлийг өмсөөд хуруунуудаа хөдөлгө. Тэгээд бээлий нь яг бидний бие махбод мэт, харин бидний гар бидний сүнс мэт гэдгийг тайлбарла. “Сүнсний маань Эцэг хэн юм бэ?” гэсэн асуултад хариулт олохын тулд Малахи 2:10-ын эхний хоёр өгүүлбэрийг анхааралтай сонсохыг хүс. Самбар дээр “Бурхан бол сүнсний маань Эцэг” гэж бич. Хүүхдүүдийг хамт уншихыг хүс. Бид, бүгдээрээ нэгэн том гэр бүл—Бурханы гэр бүлийн гишүүд гэдгийг тайлбарлан хэл.

Ойлголтыг чухалчил: Нэгэн гэр бүлийн зургийг үзүүлээд Тэнгэрлэг Эцэг биднийг дэлхий рүү илгээхдээ: “Тэрээр биднийг гэр бүлд илгээсэн хэмээн онцлон хэл.” Гэр бүл нь

хэдэн гишүүнтэйг хуруугаа гозойлгон харуулахыг хүс. Хүүхдүүдэд “Тэнгэрлэг гэр бүл болон дэлхий дэх гэр бүлийнх нь талаар заах нэгэн дууг тэд одоо дуулах болно” гэдгийг хэл. Нэг хүүхдийг өрөөнөөс гаргаад, бусад хүүхдээр гэр бүлийн зургийг нуулга. Өрөөнөөс гарсан хүүхдийг оруулж, гэр бүлийн зургийг хайх хооронд ангийн бусад хүүхдүүд “Би Бурханы хүүхэд” дууг дуулна (ХДН, 2–3). Зургийг хайж буй хүүхэд нуусан зургаас холдох үед хүүхдүүд суусан хэвээр байж, харин ойртох үед аажмаар суудлаас нь босго. Цаг байгаа бол цааш нь хэд хэдэн удаа үргэлжлүүл. Дууны утга учрыг сайн ярилцаж, гэр бүлтэй байхын чухлыг гэрчил.

Хэрэгжүүлэхийг чухалчил: Хүүхэд бүрийг ээлж ээлжээр толинд харуул. Толинд харах бүрдээ тэд “Бурханы хүүхдийг толинд харж байна” гэдгээ санах хэрэгтэй гэдгийг хэл.

Биет юмс ашиглах хичээлүүд

“Бодит юмс ашиглах хичээлүүд маань биет бус зарчмуудыг биет зүйлстэй зүйрлэж заадаг” (TNGC, 164).
Бодит юмс ашиглаж заах энэхүү хичээл нь хүүхдүүдэд сүнс нь бие махбодтойгоо ямар уялдаа хамааралтайг ойлгоход нь тусална.



2 дахь долоо хоног: Есүс Христ бол Бурханы Хүү

Ойлголтыг чухалчил: Самбар дээр дараах гурван зургийг тогтоо: Иохан Есүст баптисм хүртээж байгаа нь, Христ Нифайчуудад үзэгдсэн нь, мөн Анхны Үзэгдэл. Хүүхдүүдийг баг болгон хуваагаад, баг тус бүрд дараах судрыг нэг нэгээр нь өг: Матай 3:16–17; 3 Нифай 11:6–8; Иосеф Смит—Түүх 1:17. Тэднийг баг тус бүрдээ тухайн судрын эшлэлийг тайлбарласны



дараа (1) Үйл явдал, (2) Тэнгэрлэг Эцэг юу гэж хэлсэн, (3) Тийм нөхцөл байдалд байсан бол тэдэнд ямар санагдах байсан тухайгаа бусад хүүхдүүдэд тайлагнана гэдгийг хэл. Нэг хүүхдээр Иохан 5:39-ийг уншуул. Бид судруудаас уншиж, залбирч байвал Есүс Христ бол Бурханы Хүү гэсэн гэрчлэлтэй болно гэдгийг тайлбарла.



Зөвлөмж: *Ахлагч Даллин Х.Өүкс хэлэхдээ: “Их Эзэний сүнс-тэй нэгдмэл байлгах, биднийг нэгтгэж, сургаалаас суралцаж мөн заахад минь тусалдаг Сүмийн дууллаудын ашиг тусыг бид илүү ихээр гаргах хэрэгтэй” гэжээ. (Conference Report, 1994 он, 10-р сар, 13; эсвэл Ensign, 1994, 11-р сар, 12). Зөвлөмжүүд болон үйл ажиллагаа гэсэн хэсгээс дуу хөгжмийг хуваалцах цагт ашиглах олон янзын арга замуудыг харна уу.*

3 ба 4 дэх долоо хоног: Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ надад хайртай

Ойлголтыг чухалчил: Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ биднийг хайрладаг тухай дууны эхний нэг хоёр ноотыг төгөлдөр хуур дээр тоглож өгөхийг хөгжимчнөөс хүс. Тэгээд хүүхдүүдээр дууг таалга. Хүүхдүүдийг зөв таатал нь нэг нэг ноотоор нэмж тогло. Дууг хамтдаа дуулаад, Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн хайрын талаар энэ дуунд юу гэж зааж буйг ярилц. Хүүхдүүдийн санаануудыг самбар дээр жагсаан бич. Дуу тус бүрд давтан хий. Дараах дуунуудыг ашиглаж болно: “My Heavenly Father Loves Me” (ХДН, 228–229), “Thanks to Our Father” (ХДН, 20), “I Feel My Savior’s Love” (ХДН, 74–75), мөн “Би Бурханы хүүхэд” (ХДН, 2–3).

Хэрэгжүүлэлтийг чухалчил: Хүүхэд бүрд цаас өгөөд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ хүүхдүүдэд хайртай гэдгийг мэдсэн нэг арга

замыг зурахыг хүс. Самбар дээр бичсэн санаануудаас ашиглаж болно гэдгийг хэл. Зургуудыг нийлүүлж скождоод дамарт хайрцганд (TNGC, 178–179) эсвэл дамарт хуйлсан мэт хуйл. Хөгжимчнөөс дээр жагсаасан дуунуудын аль нэгийг нь тоглож өгөхийг хүс.

Ойлголт ба хэрэгжүүлэхийг чухалчил: Тэнгэрлэг Эцэгийн биднийг хайрлах хайраа үзүүлдэг арга замууд болон бидний Түүнийг хайрлах хайраа үзүүлдэг арга замуудыг тус тусдаа жижиг цаасан дээр бич. Цааснуудыг саванд хийгээд хүүхдүүдээр нэг нэгээр нь сугалуул. Гаргаж ирсэн цаас бүрийг чангаар унш. Хэрвээ Тэнгэрлэг Эцэгийн хайрын тухай бичсэн байвал нэг гарыг нь өргүүл. Харин цаасан дээр бидний Тэнгэрлэг Эцэгийг хайрлах хайраа үзүүлдэг арга зам бичигдсэн байвал хоёр гараа зүрхэн тушаа тавихыг сануул.

Хөгжмийн удирдаачид зориулсан тусламж

“Аврагч надад хайртайг мэднэ” (энэ төлөвлөгөөний 28–29-р хуудсыг үз) дууг сурахад нь хүүхдүүдэд тус болох үүднээс дараах зүйлсийг анхаар:

Нифайчуудын хүүхдүүдийг адисалж буй Аврагчийн зургийг үзүүлээд, 3 Нифай 17:11–24-г буй түүхийг өөрийн үгээр ярьж өг.

Дууны эхний мөрийг хүүхдүүдэд дуулж өгөхдөө “үзэсгэлэнт газар” гэдэг хэллэг дээр үйлдэл (хоёр гараа хоёр тийш нь тэлэх гэх мэт) оруулж өг. Хүүхдүүдийг хамт дуулж, үйлдлийг хамт хийхийг хүс. Дууны мөр бүрд тохирох үйлдлийг бодож олохыг хүс. Тэгээд хамтдаа дуулж хамтдаа үйлдлүүдээ хийцгээ.



Хүүхдүүд өөрсдийн зурсан, бүтээсэн зүйлсийг харах их дуртай байдаг. Хэрэв та дамартай хайрцаг хийсэн бол үүнийг дараа нь өөр хичээлүүдэд ашиглах боломжтой. Энэ үйл ажиллагаанд мөн зургуудыг нийлүүлэн наагаад, энгийн дамарт хийн ашиглаж болно.

Есүс Христ бол миний Аврагч мөн Гэтэлгэгч

Дуу: “Тэр Өөрийн Хүүгээ илгээсэн” (ХДН, 34–35)

“Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын гани, Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би тэдэнд Ариун Сүнсийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

Зөвлөмж: Сургаалыг

урьд нь мэдэж авсан зүйлтэй нь холбогдуулан яривал хүүхдүүд сайн ойлгоно. Хичээлээ эхлэх бүрдээ өмнөх долоо хоногт заасан сургаалаа дахин товчхон нэг сануулаад, өнөөдөр заах үнэн сургаалтай холбогдуул.

Хөдөлгөөнөөр суралцах нь

Хүүхдүүд хөдөлгөөнт үйл ажиллагаа хийж суралцсанаар илүү сайн сурч, илүү удаан санах болно.

1 дэх долоо хоног: Есүс Христ бол миний Аврагч мөн Гэтэлгэгч

Ойлголтыг чухалчил: Сүүлийн зоог, Христ Гетсеманид, Цовдлолт болон Амилуулалт зэрэг зургуудыг өрөөн дотор тойруулан тавь. Зургуудыг Аврагчийн амьдралын сүүлийн долоо хоногт болсон үйл явдлуудаас сэдэвлэсэн гэдгийг хэл. Аль нэг зурагтай холбогдолтой судрын хэсгээс унших болно. Аль зураг нь холбоотой болохыг дотроо бодохыг хүс. Лук 22:13–14, 19–20-ийг

унш. Бүгдээрээ зураг дээр ямар үйл явдал болж байгааг ярилц. Бусад зургийг ч мөн адил тайлбарла (Гетсемани: Лук 22:39–44; Цовдлолт: Лук 23:33–34, 46; Амилуулалт: Иохан 20:11–18). “Тэр Өөрийн хүүг илгээсэн” (ХДН, 34–35) эсвэл “Есүсийн тухай бодохоор” (ХДН, 71) гэх мэт дуунуудыг дуул. Бид Тэнгэрлэг Эцэгтэй дахин амьдарч болохын төлөө Есүс амиа өгсөн гэдгийг гэрчил.



2 ба 3 дахь долоо хоног: Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бүх хүн төрөлхтөн аврагдана

Сургаалыг таньж мэд: самбар дээр Итгэлийн тунхгийн 3-ыг бичиж хамтдаа давтан хэл. Хүүхдүүд ямар нэг үгийг ойлгохгүй бол товчхон тайлбарлаж өг. (Жишээлбэл: Цагаатгал гэдэг нь бидэнд наманчлах, Бурханд эргэн очих боломжийг олгосон Есүсийн хийсэн зүйл) Нэг хоёр үгийг арилгаад дахин хамтдаа хэл. Хүүхдүүдийг цээжлэхэд нь тусалж давтан хэл.

Ойлголтыг чухалчил: Доорх түүхийг хүүхдүүдэд ярьж өгөөд хамтран жүжигчилсэн тоглолт үзүүлэхэд урь. “Нэгэн эр замаар алхалж явав гэнэ (байрандаа алх). Тэгтэл гүнзгий нүхэнд уначихав (доош суу). Тэр хэчнээн хичээсэн ч гарч чадсангүй (гарах гэж хичээж байгаа дур эсгэ). Тэрээр тусламж эрэн хашхирлаа (чимээгүйхэн тусламж эрэн дууд). Өөр нэг хүн тэр зам дээр явж байлаа. Тэрээр нөгөө хүний тусламж эрэн

орилохыг нь сонсчээ (*Ахин чимээгүйхэн тусламж эрэн хашир*). Тэрээр нүх рүү шат унжуулж өгөв. Тэр хүн шатаар авирсаар нүхнээс гарчээ (*шатаар авирч буй мэт дүр эсгэ*). Тэр хүн аврагдлаа.” Тэр хүн нүхэнд байхдаа болон аврагдсаны дараагаар ямар мэдрэмжтэй байсан тухай ярилц. Бид гэм нүгэл хийсэн үед энэ нь яг л өөрсдийнхөө хүчээр гарч чадахааргүй тийм гүнзгий нүхэнд унасантай адилхан гэдгийг ойлгуулан хэл. Есүсийн зургийг үзүүлээд тэр хүнд нүхнээс гарахад нь өөр нэгэн хүн тусалсантай адил Есүс Христ бидэнд Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очиж хамт амьдрахад тусалж, биднийг аварч чадна гэдгийг хүүхдүүдэд ойлгуул.

Хэрэгжүүлэхийг чухалчил: Хүүхдүүдийг Алма 7:11–12 уншихад уриад Есүс бидний төлөө юу хийснийг олж мэд. Хүүхдүүдээс олж мэдсэн зүйлээсээ хуваалцахыг хүс. Бид гомдох, гуних, айх эсвэл өвдсөн үед Есүс биднийг ойлгодог гэдгийг хэл. Тэрээр бидэнд

эдгээрийг давж гарахад тусалж чадна. Дараах өгүүлбэрийг самбар дээр бич:

_____ учраас би Аврагчдаа талархдаг.

_____ Аврагч надад туслах болно.

Хэдэн хүүхдийг самбарт гарч өгүүлбэрийг нөхөж бичихийг эсвэл бүх хүүхдээс хажуу талынхаа хүүхдэд өгүүлбэрийг хэрхэн төгсгөхөө хэлэхийг хүс.

Ойлголтыг чухалчил: Судруудад

Цагаатгалын ачаар адислагдсан олон хүний тухай түүхүүд байдаг талаар хуваалц. Тэдний зарим нь: Залуу Алма (Алма 36:5–27-ы үз), Паулу (Үйлс 8:1–3; 9:1–20), мөн Инос (Инос 1:1–8) нар юм. Түүхийг ярьж өгөөд хүүхдүүдтэй давтан ярилц. Базаж бөөрөнхийлсөн цаасыг нэг хүүхэд рүү шидэж тухайн түүхийн талаар нэг зүйл хэлэхийг хүс. Цаасыг буцааж шидэхийг хүс.

Хүүхдүүд тухайн түүхийн талаар ихэнх чухал зүйлсийг дурдах хүртэл үргэлжлүүл.

Цагаатгалын талаарх гэрчлэлээ хуваалц.

Зөвлөмж: Хүүхдүүд хөдөлгөөнөөр болон үйл ажиллагаагаар суралцдаг. Түүхийг тэдэнд ярьж байхдаа хүүхдүүдийг энгийн үйл хөдлөл хийлгэж идэвхтэй оролцуул. Үйл ажиллагааны дараагаар суралцах үйл ажиллагааныхаа бэлтгэл ажил болгож үйл ажиллагаа эсвэл тоглоомоо аажмаар дуусгаж тэдэнд тусал. Жишээлбэл: хүүхдүүдээр дууны хэдэн мөрийг дуулуул, эсвэл хоёр гараа сунгаж бариад дуулж байхдаа өөрийг нь сайн харахыг хүс. Хоёр гар ойртох тусам намуухан дуулах ёстой. Тэднийг хүндэтгэл бишрэлтэй байсанд нь таларх.

4 дэх долоо хоног: Есүс Христ амилсан, тиймээс би ч мөн амилах болно

Ойлголтыг чухалчил: Хүүхдүүдийг баг болгон хуваагаад тус бүрд нь Амилуулалттай холбогдолтой үйл явдлыг харуулсан зургийг өг (жишээлбэл: Цовдлолт, Христийг оршуулсан тухай, хоосон бунхан, Мариа ба амилуулагдсан Их Эзэн болон Есүсийн шавь нартаа шарх сорвио үзүүлж байгаа гэх мэт зургийг ашиглаж болно).

Өөр хүүхдүүдэд зургаа үзүүлж болохгүй гэдгийг сануулан хэл. Өөрсдийн зурганд нь ямар үйл явдал гарч буйг бусад хүүхдүүдээр таалгахын тулд баг тус бүр зургийнхаа талаар хэдэн түлхүүр үгийг хэлэх хэрэгтэй. Тэд зөв таасан үед зургийг хүүхдүүдэд үзүүл. Есүс Христ амилсан учраас бид ч мөн бүгд амилуулагдах болно гэдгийг тайлбарлан хэл.



Хүүхдүүд суралцах үйл явцад оролцох дуртай.

Хуваалцах цагаа төлөвлөх үедээ, суралцах үйл ажиллагаанд аль болох олон хүүхдийг оролцуулах арга замыг төлөвлө. Жишээлбэл: энэ үйл ажиллагаанд ганц хоёр хүүхэд гэхээс илүүтэй гурваас дөрвөн хүүхэдтэй баг хамрагдана.

Хөгжмийн удирдаачид зориулсан тусламж

“Тэр Өөрийн Хүүгээ илгээсэн” дууг сурахад нь туслахын тулд (*ХДН, 34–35*) дараах зүйлсийг анхаарна уу:

- Дуулж байхдаа, “Тэр Өөрийн Хүүгээ илгээсэн” гэдэг үгсийг хэдэн удаа хэлж буйг хуруу даран тоолохыг хүс эсвэл

асуулт дуулах үедээ босож, хариулатыг нь дуулах үедээ суухыг хүс.

- Хүүхдүүдийг хоёр багт хуваа. Нэг баг нь асуултуудыг дуулж харин нөгөө баг нь хариултуудыг дуулна.

Бурхан бошиглогчдоороо дамжуулан ярьдаг

Дуу: “Бошиглогчийг дага” (ХДН, 110–111)

“Тэр эртнээс ариун эш үзүүлэгчдийнхээ амаар дамжуулан айлдсанчлан” (Лук 1:70).

Энд дурдах санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би тэдэнд Ариун Сүнсний мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

Зөвлөмж: Хүүхдүүд мэдээний зарчмын талаар ойлгосноо бусдад хуваалцсанаараа Сүнснийг мэдэрнэ. Тэд юу сурснаа үгээрээ, зурсан зургаараа мөн дуугаар илэрхийлдэг.

1 дэх долоо хоног: Бошиглогчид Бурханаас дуудагдсан

Сургаалыг таньж мэд: Дараах үгсийг тус тусад нь жижиг цаасан дээр бич: Бошиглогчид, бол, Бурханаас, дуудагдсан. Цаасыг хүүхдүүдэд тарааж өг. Хүүхдүүдийг үгсийг буруу дараалалтай байхаар Хүүхдийн хэсгийн урд гаргаж зогсооно. Бусад хүүхдээс үгсийг зөв дараалалд байрдуулахыг хүс. Өгүүлбэрийг хамтдаа давтан хэл.

Ойлголтыг чухалчил: Мосе, Лихай болон Иосеф Смит нар хэрхэн Бурханаас дуудагдсан талаар түлхүүр өгүүлбэрүүдийг бэлтгэ. Жишээлбэл: Мосегийн талаарх түлхүүр нь: “Бурхан дүрэлзэн шатаж буй бутан дундаас намайг дуудсан” “Бурхан надаар Библийн эхний таван номыг бичүүлэхээр дуудсан” мөн “Бурхан надаар өөрийн хүмүүсийг Египетээс удирдуулан гаргуулахаар дуудсан.” Эдгээр бошиглогчийг төлөөлүүлэхээр гурван хүүхдийг сонгоод түлхүүр өгүүлбэрүүдийг Хүүхдийн хэсгийн бусад хүүхдүүдэд хүргүүл. Тэр бошиглогч хэн болохыг гараа өргөн хэлэхийг хүс. Хүүхдүүдээр хариултыг хамтад нь хэлүүл. Бошиглогчдыг таньсны дараа

тэдний талаарх судрын эшлэлүүдийг унш (Мосе: Египетээс гарсан нь 3:4–5; Лихай: 1 Нифай 1:5–6; Иосеф Смит: Иосеф Смит—Түүх 1:16–17). Мосе Бурханаас дуудагдсан, Лихай Бурханаас дуудагдсан, мөн Иосеф Смит ч Бурханаас дуудагдсан гэдгийг онцгойлон хэл. Бошиглогчид Бурханаас дуудагддаг гэдгийг сануул.

Хэрэгжүүлэхийг чухалчил: Хүүхдүүдээс “Өнөө үеийн амьд бошиглогчийг хэн гэдэг вэ?” гэж асуу. Сүмийн одоогийн Ерөнхийлөгчийн зургийг үзүүл. Тэрээр Бурханаас дуудагдсан гэдгийг тайлбарла. Одоогийн бошиглогчийг хэрхэн дагах тухай анги ангиараа хоорондоо ярилцахыг хүс. Анги бүрээс нэг хүүхдийг гаргаж ангийнхаа хэсгүүдэд ярилцсан нэг зүйлийг үйлдлээр үзүүлэхэд урь. Үзүүлсэн үйлдэл нь юу болохыг бусад хүүхдүүдээр таалаг. Бошиглогчийг ийм арга замаар дагах нь түүний амьдралыг хэрхэн адисалж болох талаар хуваалцахыг тухайн хүүхдээс асуу.

2 дахь долоо хоног: Бошиглогчид Есүс Христийн талаар гэрчилдэг

Ойлголтыг чухалчил: Хуваалцах цагаа эхлэхээс өмнө Есүс Христийн зургийг самбар дээр тавиад Исаиа, Иохан Баптист, Нифай болон

Иосеф Смит нарын зургийг дээр нь тавь. Анги тус бүрд нэг судрыг даалгаж өг: Исаиа 9:6; Марк 1:6–8; 2 Нифай 25:26; Сургаал ба Гэрээ 76:20–24. Хүүхдүүдийг анги тус

Сургаалыг танин мэдэх


Үйл ажиллагаа явуулахдаа зааж буй сургаалаа тодорхой таньж мэд. Ингэснээр хүүхдүүд үүнийг илүү сайн ойлгож, илүү сайн хэрэгжүүлэхэд нь дөхөм болно.

Үг харахад энд дар.



бүрдээ оногдсон судраа уншиж ярилцаад хэн гэдэг бошиглогч Есүс Христийн талаар юу гэж гэрчилж буйг ялгаж танихыг даалга. Нэг ангийг сонгон уншсан бошиглогчийн зургийг олж Хүүхдийн хэсгийн хүүхдүүдтэй юу

сурснаа хуваалцахыг хүс. Бошиглогчдын зургийг самбар дээрээс ав. Үлдсэн гурван бошиглогчийн зургийг нэг нэгээр нь ав. Есүс Христийн зургийг заагаад бүх бошиглогч Есүс Христийн талаар гэрчилдэг байсныг хэл.



Зөвлөмж:

Хүүхдүүдийг өөрсдийнх нь судраас уншуулснаар энэ нь тэдэнд судруудын чухлыг ойлгуулж, Сүнсийг урьдаг. Хэрэв боломжтой бол, наад зах нь нэг эшлэлийг тантай хамт уншихад урь. Хүүхдэд хуудасных нь дугаарыг хэлж тухайн шүлгийг судар дээрээсээ зааж, эшлэлийг олоход нь татаулж болно. Тухайн шүлгийг хүүхдүүдтэй хамтдаа чангаар уншиж болно.

Зөвлөмж: Энэ сард та дараах зааж аргуудыг хэрэглэсэн: өгүүлбэрийг зөв дараалалд оруулах, судруудаас унших, санааг ярилцах буюу үйлдлээр үзүүлэх, зураг үзэх, хөдөлгөөнт үйл ажиллагаанд оролцох болон өмнөх үйл ажиллагаануудаа давтах гэх мэт. Эдгээр арга барилыг өөр хичээлд ашиглаж болох боломжуудыг эрэлхийл.

3 дахь долоо хоног: Бошиглогчийг дагаснаар аюулгүй байж чадна

Ойлголтыг чухалчил: Мосегийн зургийг үзүүлээд Мосе бол өөрийн хүмүүсийг аюулгүй байдал уруу хөтлөн удирдсан бошиглогч байсан гэдгийг тайлбарлан хэл. Израилчууд Египетийн хаан Фараоны боолчлолд байхад Их Эзэн Мосед тэднийг Египетээс удирдан гарга гэж хэлсэн. (Египетээс гарсан нь 3:10 үз). Египетээс гарсан нь 14-г буй түүхийг ярьж өгөөд хүүхдүүдийг тантай хамт жүжигчлэн үзүүлэхэд урь. Жишээлбэл: “Хүмүүс Мосег элсэн цөл дундуур даган явсан (дороо алхал). Тэд тэнгист тулж ирсэн (гараараа давалгаа хий). Хүмүүс эргэж харсан (эргэж хар), тэгээд Фараон ба түүний цэргүүд хойноос нь хөөж байхыг харсан (давхилдаж байгаа морьдын

чимээ гаргаж дороо давхи). Тэд их айж байлаа (айсан дүр үзүүл).” Египетээс гарсан нь 14:13-ыг уншаад түүхээ үргэлжлүүл. “Их Эзэн Мосед таягаа өргө хэмээн хэлсэн (таягаа өргөж буй мэт дүр үзүүл) тэгтэл тэнгис хоёр тийш хуваагдаа (хоёр гараа алдал). Хүмүүс Мосег дагаж тэнгисийг хуурай газраар аюулгүй гаталж нөгөө талд нь гарлаа (дороо алхал). Фараоны цэргүүд тэднийг дагахыг оролдсон боловч Их Эзэн Мосед гараа өргө гэж хэлэхэд тэнгисийн ус дахин нийллээ (гараа нийлүүл). Фараоны цэргүүд тэнгист живжээ. Хүмүүс бошиглогчийг дагасан учраас аюулгүй байв”.



Хүүхдүүд сурахын тулд юу хийх вэ?

Үйл ажиллагаандаа бэлтгэж байхдаа энэ асуултыг асуувал хүүхдүүд сайн оролцож, сайн сурдаг. Жишээлбэл: зураг дээр хүүхдүүд Мосе Улаан тэнгисийг хоёр хэсэг хувааж байгаа тухай жүжигчилсэн үзүүлбэр үзүүлж байна.

4 дэх долоо хоног: Бурхан бошиглогчдоор дамжуулан ярьдаг

Энэ сарын хуваалцах цагууд дээр хүүхдүүдийн сурсан сургаалыг давтан ярилц. Жишээлбэл:

- Өмнөх хуваалцах цаг дээр хийж байсан үйл ажиллагаануудыг давтаж эсвэл дэлгэрүүл.
- Өнөө цагийн бошиглогчийн зургийг харуулж “Хэрэв энэ хүн хэн болохыг мэдэж байвал гараа өргө” гэж хэл. Хажуугийнхаа

хүүхдийн чихэнд нэрийг нь шивнэн хэлэхийг хүс. Бошиглогчийн талаар ямар сэтгэгдэлтэй байдгийг хэд хэдэн хүүхдийг урьж хуваалцуул.

- “Бошиглогчийг дага” дууны эхний бадгийг дуул (ХДН, 110–111) энэ хооронд хүүхдүүд бошиглогчийг дагахын тулд юу хийх ёстойг үйлдлээр үзүүлнэ.

Есүс Христ Сайн мэдээний бүрэн байдлыг Иосеф Смитээр дамжуулан сэргээсэн

Дуу: “Есүс Христийн Сүм” (ХДН, 77)

“Анхны Сүмд байсан тэрхүү зохион байгуулалтад бид итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:6).

Энд дурдах санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүдэд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би тэдэнд Ариун Сүнсийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

Зөвлөмж: Баг болгон хувааснаар илүү олон хүүхэд оролцох боломжтой. Үйл ажиллагаанд бүх хүүхдийг оролцуулахын тулд хүүхдийнхээ тооноос хамааран хэдэн баг болгон хуваахаа шийдээрэй (1 дэх долоо хоногийг хар).

1 дэх долоо хоног: Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ Иосеф Смитэд үзэгдсэн нь

Сургаалыг таньж мэд: Есүс Христ энэ дэлхий дээр амьдарч байхдаа Өөрийн Сүмийг зохион байгуулсан гэдгийг ойлгуул. Өнөө үед бид тэр сүмийг “Анхны Сүм” хэмээн нэрлэдэг. Есүсийг нас барснаас хойш удалгүй Түүний сайн мэдээ дэлхий ертөнцөөс авагдсан ба олон жилийн дараа сайн мэдээг Иосеф Смитээр дамжуулан сэргээсэн. Дараах өгүүлбэрүүдийг тус тусад нь дөрвөн ширхэг зурвас цаасан дээр бич.

1. Иосеф Смит Библиээс “Харин та нарын хэн нэгэн нь _____, Бурханаас гуйг” гэсэн өгүүлбэр уншсан. (Иосеф Смит—Түүх 1:11)
2. Иосеф Смит _____ уруу _____ явжээ. (Иосеф Смит—Түүх 1:14)
3. Иосеф чанх орой дээр нь гэрлэн _____ байхыг харсан. (Иосеф Смит—Түүх 1:16)

4. Тэнгэрлэг Эцэг Есүс Христ уруу заагаад “Энэ бол _____” хэмээн хэлсэн. (Иосеф Смит—Түүх 1:17)

Хүүхдүүдийг дөрвөн баг болгон хуваагаад баг тус бүрд цаасан хайчилбараа өг. Хүүхдүүдээр судрын хэсгийг уншиж хоосон орхисон үгсийг нөхүүл. Тэднээс хоосон орхисон зайг нөхөхийн оронд нэг нэгэндээ хариултыг нь шивнэн хэлэхийг хүс. Тэгээд хүүхдүүдийг цаасаа нөгөө багт шилжүүлэн судруудын бүх орхигдсон үгсийг олгож үргэлжлүүл. (Хариулт: 1. мэргэн ухаанаар дутвал, 2. ой, залбирахаар; 3. багана; 4. Хайртай Хүү)

Ойлголтыг чухалчил: Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ Иосеф Смитэд үзэгдсэн талаар ойлгоход нь туслахын тулд Балчир хүүхдийн ангийн гарын авлага болох *Бяцхан үрсээ болгоогтун*, (88–91-р хуудсыг үз)-д буй үйл ажиллагаанууд, үзүүлэн, хуруун тоглоом зэргээс ашиглаж болно.

2 дахь долоо хоног: Иосеф Смит Мормоны Номыг Бурханы хүчээр орчуулсан

Ойлголтыг чухалчил: Янз бүрийн хэлбэр дүрс ашиглан самбар дээр *Бурханы хуч чадал* гэж бичнэ (жишээлбэл, та үсэг

тус бүрийг нэг бэлэг тэмдгээр орлуулан бичиж болно). “Өгүүлбэрийг уншиж чадах хүн байна уу” хэмээн асуу. Аль үгсийг ямар дүрсээр орлуулсан тухаахүүр буюу хариултыг самбар дээр бичээд хүүхдүүдийг баг тус бүрдээ тухайн өгүүлбэрийг тайлж уншихыг оролдуул. (Хариултыг

◆	▼	●	▶	×	*	▲	
▶	✓	♣	♣	×	♥	×	
δ = ♥	ρ = ●	α = ×	λ = ■	н = *	Б = ◆	у = ▼	х = ▶
γ = ✓	Ы = ▲	ч = ♣					

Сургаалыг таньж мэдэх

Зааж буй сургаалаа тодорхой таньж мэд. Энэ нь хүүхдүүдэд илүү сайн ойлгож, хэрэгжүүлэхэд нь дөхөм болдог. Сургаалын үгсийг харж нүдлэн, цээжлэх арга замыг бодолцож үз.

чангаар хэлэхгүй байхыг хүүхдүүдэд сануул.) Өгүүлбэрийг хамтдаа унш. Сургаал ба Гэрээ 1:29-ийг унш. Бурханы тусламжгүйгээр Иосеф Смит алтан ялтсууд дээрх бичгийг уншиж чадахгүй байсан гэдгийг тайлбарлаж өг. Хүүхдүүдээс Иосеф

Смит Мормоны Номыг хэрхэн орчуулсан талаар мэддэг зүйлээ хуваалцахыг хүс. Хэд хэдэн хүүхдээс Мормоны Номын талаар ямар сэтгэгдэлтэй байдгаа хуваалцахыг хүс.



Зөвлөмж: *Драмын жүжигчилсэн тоглолтод Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг дуурайн дүрслэх нь зохисгүй.*

Зөвлөмж: *Хүүхдийн хэсгийн дуунуудыг зааж байхдаа ашигла. Энэ нь хүүхдүүд юу заалгаснаа санахад тусална. “Удаан сурах зарим сүнслэг зүйлсийг . . . дуу хөгжсөөр дамжуулан маш хурдан сурах чадвар бидэнд байдаг” (Бойд К. Пакэр, TNGC, 46).*

3 ба 4 дэх долоо хоног: Есүс Христ Иосеф Смитээр дамжуулан сайн мэдээгээ сэргээсэн

Сургаалыг таньж мэдэн, ойлголтыг чухалчил:

Есүсийг нас барснаас хойш удалгүй Түүний сайн мэдээ дэлхий ертөнцөөс авагдсан ба олон жилийн дараа сайн мэдээг Иосеф Смитээр дамжуулан сэргээсэн гэдгийг сануулан хэл. Сэргээх гэдэг нь ямар нэгэн зүйлийг дахин буцаан нэгтгэхийг хэлнэ. Сүмийн зургийг энгийнээр зурж үзүүлсний дагуу хаягла (Ефес 2:20; 4:11–13). Христ дэлхий дээр байхдаа Өөрийн Сүмийг байгуулсан гэдгийг тайлбарла. Урвалтын талаар заах үедээ зургийг хэсэг хэсэг болгон хайчил. Төгөлдөр хуурчийг “On a Golden Springtime” (ХДН, 88) дууг тоглох зуур зургийг



Зураг энд дар.

эргүүлэн нийлүүлэх буюу эвлүүлэхийг хүс. Гуравдугаар бадгийг хамтдаа дуул.

Ойлголтыг чухалчил: Хэсгийнхээ гишүүдээс Сэргээлтэд гар бие оролцсон хүмүүсийн дурд орж ярихыг хүс (Иосеф Смит эсвэл [Иосеф Смит—Түүх 1:8–20], Моронай тэнгэр элч [Иосеф Смит—Түүх 1:29–35, 42–49], Гурван гэрч [“Гурван гэрчийн гэрчлэл”], эсвэл Иохан Баптист [С ба Г 13-ыг үз]). Зочид маань тэдний өмсдөг байсан шиг хувцас өмсөж болно. Хүүхдүүдийг баг болгон хуваа. Зочдыг хэн гэдгийг танилцуулж, тэдний талаар хүүхдүүдийн юу мэдэхийг нь яриул. Зочдоос дурд нь орсон хүнийхээ талаар гэрчлэлээ хуваалцахыг хүс.

Энэ үйл ажиллагаанд хэрэглэгдэж буйтай ижил зурсан зургийг ашиглаж болно. Хэрэв танай Хүүхдийн хэсэг олон хүүхэдтэй бол хэд хэдэн багт хувааж болно.

Хөгжмийн удирдаачид зориулсан тусламж

“Есүс Христийн Сүм” гэдэг дууг сурахад нь хүүхдүүдэд туслахын тулд (ХДН, 77) дараах зүйлсийг хийж болно:

- Хүүхдүүдийг ямар нэг гэр бүлийн гишүүн бол босож зогсохыг хүс. Өөр тэдний харьяалагдаж болох баг, клуб эсвэл сүм зэргийг нэрлэж мөн адил босохыг хүс.



Хүүхдүүдээр харьяалагдах гэдэг нь ямар утгатай болохыг тайлбарлуул (аливаа юмны нэгэн чухал хэсэг байх). Есүс Христийн зургийг үзүүлж, Сургаал ба Гэрээний 115:4-ийг уншиж, тухайн дуугаа танилцуул.

- Дууны мөр бүрийг дуулахын өмнө асуулт тавьж, хариултыг нь тухайн мөрийг дуулах үед олж сонсоно. (Жишээлбэл: Би хаана харьяалагддаг вэ? Би ямар хоёр зүйлийг мэддэг вэ? Би Түүнийг яаж дагах вэ?) Тэгээд дараа нь тухайн мөрийг хүүхдүүдтэй хамт дуул. Хүүхдүүд дууг суртал давт.
- Хүүхдийн хэсгийг хоёр багт хуваагаад, нэг багийн хүүхдүүд дууны мөр бүрийн эхний хоёр үгийг дуулж (Би харьяалагддаг, Би мэднэ, гэх мэтчилэн), нөгөө хэсгийн хүүхдүүд мөрийг дуустал нь дуулна. Хэсгүүд дуулах хэсгээ солилцоод давт.

Хүүхдийн дууны ном-оос хүссэн дуугаа сонгон дуул.

Зөвлөмж: Цөөн хүүхэдтэй олон баг болгон хувааснаар илүү олон хүүхэд оролцох боломжтой болж байгаа юм. Хуваалцах цаг дээр хүүхдүүд анги ангиараа ялгаран суусан байдаг. Нэг ангийн хүүхдүүдийг нэг баг болгон хэсгийн үйл ажиллагаанд оролцуулж болно. Ангийн багш нар нь хүүхдүүдийн оролцоо хийгээд хүндэтгэлтэй байдлаа хадгалахад нь тусална.

Сайн мэдээний зарчмууд болон ёслолууд нь намайг Есүс Христ уруу хөтөлдөг


“Сайн мэдээний анхдагч зарчмууд хийгээд ёслолууд нь, нэгдүгээрт: Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл, хоёрдугаарт: Наманчлал, гуравдугаарт: Нүглүүдийн ангижралын төлөөх усанд умбуулах баптисм, дөрөвдүгээрт: Ариун Сүнсний бэлгийн төлөөх гар тавилт гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:4).

Энд дурдах санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би Ариун Сүнсийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

1 дэх долоо хоног: Намайг дуулгавартай байсан үед Есүс Христэд итгэх итгэл минь бэхэждэг

Сургаалыг таньж мэд: Есүс Христийн зургийг самбар дээр тавь. Зураг уруу хөтлөх дөрвөн шатны гишгүүр зур. Итгэлийн тунхгийн 4-ийг хүүхдүүдтэй хамт уншаад, тэднээс сайн мэдээний зарчмууд болон ёслолуудын эхнийхийг нэрлэхийг хүсэж, хэлэхээр нь шатны гишгүүр дээр бичнэ үү. Зарчим болон ёслолыг хэлэх бүрдээ хуруугаа дарж тоолоорой. Итгэлийн тунхгийн 4-ийг цээжлэхэд нь туслах арга замыг бодож ол.

Ойлголтыг чухалчил: “Итгэл” (ХДН, 96–97) дууг дуулна. Хоёр дахь бадгийн өгүүлбэр тус бүрийг зурвас цаасан дээр бич. Хүүхдүүдийг дөрвөн багт хуваагаад, баг тус бүрд нэг цаас өг. Дууны үгийн дарааллаар хүүхдүүдийг зогсоож, дуулуул. Баг бүр хоорондоо цаасаа солицож, нэг мөр дуулж, үргэлжлүүлэн давт. Дуулгавартай байх арга замуудыг дүрслэн үзүүлэхийг хүс (Үүнийг өөрийнхөө хэсэгт хийж болно эсвэл Хүүхдийн хэсгийн бүх хүүхдүүдийн дунд хийж болно). Есүс Христэд итгэх итгэлийг тань бэхжүүлсэн туршлагаасаа хүүхдүүдтэй хуваалц.



Самбар ашигла

Самбар бол үр дүнтэй заах хэрэгсэл мөн. Энгийн зураасан зураг сайн мэдээний зарчмуудыг заахад тус болно.


2 дахь долоо хоног: Би наманчилж чадна

Ойлголтыг болон хэрэгжүүлэлтийг чухалчил: Бид гэм нүгэл хийсэн үедээ Есүс Христийн ачаар наманчилдаг, өөрөөр хэлбэл нүгэл үйлдэхээ зогсоож, Бурхан уруу

эргэн хандахыг хэлнэ. Наманчлал нь гэмших, уучлал эрэх, гэм буруугаа засаж залруулах болон алдаагаа дахин давтахгүй байх зэрэг алхмуудыг агуулдаг. Эдгээр үе

шатуудыг товчхон ярилцаад, Аврагч бидэнд хэрхэн тусалж чадахыг тодруул. Хүүхдүүдийг баг болгон хуваагаад баг тус бүрд ямар нэгэн нөхцөл өгнө үү. Хүүхдүүдийг тухайн нөхцөл байдлын талаар уншаад, наманчлахын тулд “хэрэв би байсан бол” гэдгийг ярилцана.

Жишээлбэл: хэн нэг хүүхэд маш их уурлаж ах эгч нараа цохидог байв. Тэр юу хийх ёстой вэ? Есүс Христийн бидэнд олгосон наманчлах боломжид талархаж явдгаа илэрхийл.



3 дахь долоо хоног: Баптисм хүртсэнээр би Бурхантай гэрээ хийдэг

Сургаалыг таньж мэд: Амлаалт гэж юу болохыг хүүхдүүдэд дүрслэн үзүүлэхийн тулд хоёр хүүхдийг ангийн урд урин гаргаж ир. Эхний хүүхдийг “Чи _____ амлах юм бол би чамд _____ амлаж байна” гэж хэлүүл. Хоёр дахь хүүхэд зөвшөөрч, тэр хоёр гар барих хэрэгтэй. Гэрээ гэдэг нь Бурхан болон бидний хоорондох хоёр талт амлаалт юм гэдгийг тайлбарла. Самбарыг хоёр хувааж зураас татаад нэг талд нь “Бурханы амлалтууд” харин нөгөө талд нь “Бидний амлалтууд” гэж бич. Бид баптисм хүртсэнээр Бурханд амлаалт өгч, Бурхан бидэнд мөн амлаалт өгдөг.

Ойлголтыг чухалчил: Тус тусад нь цаасан дээр дараах амлалтууд болон дуунуудыг бичиж бэлтгэ: Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авна (“Есүс Христийн Сүм” [ХДН, 77]);

Түүнийг үргэлж дурсан санана (“Есүсийг үргэлж бодохын тул” [ХДН, 71]); Тушаалуудыг сахина (“Тушаалуудыг сахина” [ХДН, 146–147]); Өөрийн Сүнсээ бидэнтэй хамт байлгана (“Ариун сүнс” [ХДН, 105]); Түүнтэй амьдрахаар буцна (“Би Бурханы хүүхэд,” 3-р бадаг [ХДН, 2–3]). Цааснуудаа нэг саванд хий. Нэг хүүхдийг савнаас нэг цаас сугалж, амлаалтыг уншихыг хүс. “Хэн амлаалт өгч байна вэ? Бурхан уу, бид үү?” гэж хүүхдүүдээс асуу. Тухайн амлаалтыг самбар дээр зохих гарчгийн дор бич. Хүүхдүүдээр дууг дуулуулж, дуулж дуустал нь савыг хоорондоо дамжуул. Дуу дуусахад савыг барьж таарсан хүүхэд савнаас нэг цаас сугална. Дуу тус бүрд давтан хий. Амлаалтуудыг дахин нэг ярилцаад, баптисмын гэрээний ач холбогдлын талаар гэрчил.



Хүүхдүүдийг биечлэн оролцуулах нь

Хүүхдүүдийг биечлэн оролцуулах нь тэдний анхаарлыг төвлөрүүлж, суралцахад нь бэлтгэж өгдөг. Жишээлбэл: Энэ удаагийн хуваалцах цаг дээр хүүхдүүд амлалтыг дүрслэн үзүүлснээр эхэлсэн.

4 дэх долоо хоног: Би гишүүнээр батлуулахдаа Ариун Сүнсийг хүлээн авдаг

Сургаалыг таньж мэд: Хүүхдүүдэд гишүүнээр батлуулж буй хүүхдийн зургийг үзүүлээд зураг дээр юу болж байгааг асуу. “Ариун Сүнсний бэлэг гэж юу вэ?” хэмээн асуу. Ариун Сүнсний бэлэг гэдэг нь Ариун Сүнсстэй байнга хамт байх эрхтэй байна гэсэн үг хэмээн тодруул. “Ариун Сүнс” (ХДН, 105) дууг дуул.

Ойлголтыг чухалчил: Мелкизедек санваартан нэг ахыг Хүүхдийн хэсэгт урьж

оролцуул. Цөөн хэдэн хүүхдэд санваартан ахаас асуух хэдэн асуултыг өг. Жишээ нь: Та ямар санваартай вэ? Санваарыг та хэрхэн хүлээн авсан бэ? Та хэн нэгнийг Сүмийн гишүүнээр хэрхэн баталдаг вэ? “гар тавилтаар” гэдэг нь ямар утгатай вэ? “Ариун Сүнснийг хүлээн авах” гэдэг нь юу гэсэн үг вэ? Ариун Сүнс надад яаж туслах вэ? Ариун Сүнс тэдэнд хэрхэн тусалж байсан тухай туршлагаасаа хуваалцахыг хүүхдүүдээс хүс.

Зөвлөмж: Хүүхдүүд сайн мэдээний талаарх мэдрэмжээ хуваалцах нь Ариун Сүнсийг урин дууддаг. Хүүхдүүдийн мэдэрдэг амар тайван, хайрын мэдрэмж нь Ариун Сүнснээс ирдэг гэдгийг ойлгуул. 4 дэх долоо хоногийн хуваалцах цагийн гол анхаарал хандуулах зүйл нь хүүхдүүд Ариун Сүнс тэдэнд хэрхэн тусалсан тухай мэдэх юм. Хүндэтгэлтэй тайван уур амьсгалыг бүрдүүлснээр ийм зүйл биелнэ гэдгийг анхаарна уу.

Ариун Сүнс бүх зүйлийн үнэнийг гэрчилдэг

Дуу: “Ариун Сүнс”
(ХДН, 105)

“Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно”
(Моронай 10:5).

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би Ариун Сүнсийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

1 дэх долоо хоног: Ариун Сүнс бол Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүн юм

Сургаалыг таньж мэд: Хүүхдүүдийг гурван баг болгон хуваагаад Итгэлийн тунхгийн 1-ийг цээжлэхэд нь тусал. Нэг баг уруу заагаад “Бид Бурхан, Мөнхийн Эцэг” хэмээн хэлүү. Нөгөө баг уруу заан, “Түүний Хүү Есүс Христ болон” гэж хэлүүлээд өөр нэг баг уруу заагаад, “Ариун Сүнсэнд итгэдэг” хэмээн хэлүүлээрэй. Баг тус бүрд хэллэг тус бүрийг хэлэх боломж олдтол давтан хий (Бага насны хүүхдүүдийг өгүүлбэр бүрийг хэлэхэд хуруугаа гозойлгохыг хүсэж болно). Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ, Ариун Сүнс нь Бурхан Тэргүүтний гурван гишүүн юм гэдгийг тайлбарла. Ариун Сүнс нь бие махбодгүй, ясгүй сүнс юм гэдгийг тайлбарла.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг чухалчил: Хүүхдүүдийг судраа нээгээд Сургаал ба Гэрээ 130:22–ыг хамтдаа уншихад урь. Ариун Сүнс яагаад бие махбодгүй болохыг сайн сонсохыг тэднээс хүс. Сургаал ба

Гэрээ 8:2–ыг унш. Хүүхдүүд таныг “оюунд” чинь хэмээн хэлэхэд толгой уруугаа зааж, “зүрх сэтгэлд чинь” хэмээн уншихад зүрх рүүгээ заах хэрэгтэйг хэл. Ариун Сүнс хэрхэн бидний оюун санаа, зүрх сэтгэлтэй ярьдаг тухай жишээнүүдийг хуваалц (Галат 5:22). Ариун Сүнсний нөлөөг мэдэрч байсан мөчийнхөө талаар хуваалцахыг хүсч болно.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг чухалчил: Хүүхдүүдийг таван багт хуваа. Баг тус бүрд дараах судрын хэсгүүдээс нэгийг өгч, Ариун Сүнс бидэнд хэрхэн тусалдаг талаар олж харахыг хүс: Иохан 14:26 (тайвшруудаг мөн заадаг); 2 Нифай 32:5 (бид юу хийх хэрэгтэйг хэлж өгдөг); Мозая 5:2 (зүрх сэтгэлийг маань өөрчилдөг); Моронай 8:26 (биднийг итгэл найдвар, хайраар дүүргэдэг); Сургаал ба Гэрээ 20:27 (Христийн талаар гэрчилдэг). Баг бүрийг сурсан зүйлсээ Хүүхдийн хэсгийн бусад хүүхдүүдэд хуваалцахад урь.

2 дахь долоо хоног: Ариун Сүнс намуухан зөөлөн дуу хоолойгоор ярьдаг

Сургаалыг таньж мэд: Намуухан дуугаар, “Миний дуу хоолойг сонсож байгаа нь хуруугаа хамартаа хүргэ” гэж хэл. Миний дуу хоолойг сонсож байгаа нь гараа толгой дээрээ тавь. Үргэлжлүүлэн, бүх хүүхдүүд таны дуу хоолойг сонсох хүртэл биеийн бусад хэсгийг нэрлэн үргэлжлүү. Гараа зөрүүлж урдаа авахыг хүсэн, үйл ажиллагаагаа төгсгөж болно. Хэдийгээр та их намуухан ярьж байсан ч хүүхдүүд дуу хоолойг чинь сонсож, заавруудыг чинь дагаж байсан гэдгийг онцлон хэл. Ариун Сүнс бидэнтэй намуухан дуу хоолойгоор ярьдаг.

Ойлголтыг чухалчил: Хүүхдийн нүдийг нь боогоод өрөөний нэг буланд зогсоо. “Хэрэв чи надад найдаж, намайг сонсох юм бол би чамайг аюулгүйгээр суудал руу чинь аваачих

болно” хэмээн түүнд хэл. “Нamuухан зөөлөн хоолойгоор” хүүхдийг суудалдаа эргэн очих зааврыг хэлж өг. “Энэ нь Ариун Сүнс биднийг хөтлөн удирддагтай юугаараа ижил вэ? гэж асуу. Нифайгийн хугарсан нум сумны талаар ярьж өгөөд, Ариун Сүнсийг Лиахонатай хэрхэн зүйрлүүлж болох тухай үзүүл (1 Нифай 16:18–32). Энэхүү товхимлын бусад хичээлд хэрэглэсэн үйл ажиллагаануудыг ашиглаж болно (гуравдугаар сар, 3 дахь долоо хоног, эсвэл наймдугаар сар, 4 дэх долоо хоног). Лиахона хүмүүсийг итгэл болон хичээл зүтгэлээс нь хамаарч удирдан залж байсан бол Ариун Сүнс зөв шударга байдлаас маань хамаарч мөн Түүний дуу хоолойг сонсвол биднийг удирдан залах болно гэдгийг тайлбарла.

Зөвлөмж: Сайн мэдээний үнэнийг судруудаас суралцах нь хүүхдүүдийн хувьд маш чухал билээ. Судруудаас уншиж байх үед анхаарлаа төвлөрүүлж, сайн сонсож ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Таныг судрын хэсгээс уншиж байхад хэдий бага насны хүүхэд ч гэсэн ганц хоёр үгийг ойлгож чадна.

3 дахь долоо хоног: Ариун Сүнс биднийг хөтлөн удирдаж хамгаална

Ойлголтыг чухалчил: Ариун Сүнс биднийг хэрхэн удирдаж, хамгаалдаг талаар хуваалцахыг багийнхаа гишүүдээс хүс. Тэд хувийн туршлагаасаа, судруудын түүхүүдээс эсвэл Сүмийн түүхээс ярьж болно (жишээлбэл: *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Вилфорд Вудрафф: Wilford Woodruff* [2004], 46–47-г үз). Хүүхдүүдийг хэд хэдэн баг болгоод баг бүр түүхүүдийг сонсож дуустал түүх яригчийг эсвэл хэсгүүдийг ээлжлүүлэн байрыг нь солиул. Түүх яригчдаа солилцож байх зуураа хүүхдүүд “Ариун Сүнс” дууг амандаа аялахыг хүс (ХДН, 105).

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг чухалчил: Самбарыг зураасаар хоёр хуваа. Нэг талын дээд талд нь “Чухал шийдвэрүүд” хэмээн бичээд харин нөгөөд нь “Ариун Сүнсийг урь” хэмээн бич. Эхний багананд амьдралынхаа туршид гаргах ёстой чухал шийдвэрүүдийг бичүүл. Эдгээр шийдвэрүүдийг гаргахад туслах Ариун Сүнсийг амьдралдаа урихын тулд тэд юу хийх ёстойг хоёр дахь багананд жагсаан бич.



Зөвлөмж: *Сүнсийг урих бас нэгэн арга зам бол сайн мэдээний үнэн зарчмуудын дагуу амьдрахын тулд тэд юу хийхийгээ тайлагнах боломжийг олгох явдал юм. Хуваалцах цаг бүрд ийм боломж хэрхэн олгох талаар бодолцож үзээрэй.*

Чухал шийдвэрүүд

Шударга бай

Баптисм хүртсэн бай

Номлолд үйлчил

Ариун Сүнсийг урь

Залбир

Сүмд ир

Судруудаас унш

Самбар ашигла

Самбар нь үр дүнтэй заах хэрэгсэл юм. Самбарыг хүүхдүүдтэй мэндлэхэд, асуулт асуухад, сургаалыг танин мэдэхэд мөн түүхүүд болон утга санаануудыг дүрслэн үзүүлэхэд ашиглаж болно (TNGC, 162–163 үз).

4 дэх долоо хоног: Ариун Сүнсний хүчээр бид бүхий л зүйлсийн үнэнийг мэдэж чадна

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг

чухалчил: Хамтдаа Моронай 10:5-ыг уншаад Ариун Сүнс бидэнд үнэнийг сурахад тусална гэдгийг гэрчил. Заримдаа бидэнд сүм дээр байхдаа, сайн үйл бүтээж байхдаа эсвэл залбирч судраасаа уншиж байхад дулаан, амар тайван мэдрэмж төрдөг гэдгийг хэл. Энэ амар тайван мэдрэмж нь Ариун Сүнс эдгээр зүйлс үнэн гэдгийг мэдрүүлж байгаа юм гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг анги ангиар нь баг болгоод баг бүрийг дараах үйл ажиллагаанаас аль нэгийг сонгохыг хүс: (1) *Бяцхан үрсээ болгоогтун* Балчир хүүхдийн ангийн гарын авлагаас шоон тоглоомыг тогло (хуудас 29, 31).

Ариун Сүнс тэдэнд хэрхэн тусалж байсан тухай туршлагаа хуваалц. (Анги бүрийн багш нарыг эхлээд өөрсдийнхөө туршлагаас эхлэн хуваалцахыг урьж болох юм.)



Хичээлүүдийг тохируулан өөрчлөх нь

Хүүхдийн насанд тохируулан хичээлүүдийг өөрчил. Балчир хүүхдийн ангийн гарын авлага болон Сүмийн сэтгүүлүүд буюу бусад Сүмээс зөвшөөрөгдсөн материалуудыг мөн ашиглаж болно.

Би Есүс Христийн үлгэр дуурайлыг дагаж чадна

Дуу: “Намайг дага”
(Сүмийн дуулал, 116)

Зөвлөмж: Хүүхдийн хэсгийн хичээлийн дундуур хөдөлгөөнтэй үйл ажиллагаа хийх нь хүүхдүүдийн идэвх оролцоог сайжруулж, анхааралтай байлгадаг. Хүүхдийн хэсгийнхээ хэмжээнээс хамаарч үйл ажиллагаа өөрчлөн тохируул. Жишээлбэл: Олон хүүхэдтэй Хүүхдийн хэсэг нь 2 дахь долоо хоног ашигласан зураг уруу хөлийн мөрийг явуулсан байдлаар ашиглахын оронд байрандаа алхаж болно.



Зөвлөмж: Олон төрлийн заах арга замыг ашиглах нь хүүхдүүдийг илүү үр дүнтэй суралцахад нь тусалдаг. Жишээлбэл: 2 дахь долоо хоногт хүүхдүүд сургаалыг танин мэдэх, зураг үзэх, мөн сургаалтай холбогдолтой хөдөлгөөнт үйл ажиллагаа хийх.

Есүс, “Намайг дага” хэмээн хэлсэн (Лук 18:22).

Энд дурдах санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би Ариун Сүнснийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

1 дахь долоо хоног: Есүс Христ Тэнгэрлэг Эцэгийг үргэлж дуулгавартай дагасан

Сургаалыг таньж мэд: Таван жижиг цаасан дээр дараах үгсийг нэг нэгээр нь бичин, ар талд нь холбогдох судрын хэсгийг бичиж бэлтгэ: *бус* (Мосе 4:2); *Миний хүсэл* (Лук 22:42); *Гэвч* (3 Нифай 27:11); *Таных* (Иохан 6:38); *биелэг* (Иохан 4:34). Хүүхдүүдийг таван баг болгоод баг бүрд нэг цаас өг. Эдгээр сударт Есүс Христ Өөрийн амьдралдаа хэрхэн амьдарсан талаарх төстэй утга санааг хэлж байгаа гэдгийг тайлбарлан хэл. Судруудынхаа утга санааг ойлгоход хүүхдүүдээ туслахыг ангийнх нь багш нараас хүс. Бүх багийг цаасаа самбарт буцаан авчирч

тавиад юу сурснаа тайлагнахыг хүс. Үгсийг зөв дараалалд оруулж өгүүлбэр болгон уншихад тань туслахыг хүүхдүүдээс хүс.

Хэрэгжүүлэлтийг чухалчил: Тэнгэрлэг Эцэгийн тушаалуудыг дагасан Есүс Христийн үлгэр дуурайлыг дагаж чадах арга замуудыг хэлүүл. Хүүхэд бүрээс зурвас цаасан дээр нэг санал бичих юмуу зурахыг хүс. Зурвас цааснуудаа холбоод гинжин холбоо үүсгэ. Дуулгавартай байдлын үйлдэл бүрээр гинж маань уртсаж байгаа шиг дуулгавартай байх бүрд бидний итгэл өсөх болно гэдгийг тайлбарла.



Сургаалыг таньж мэдэх

Үйл ажиллагаа явуулж байхдаа зааж буй сургаалаа илүү тодорхой ойлгомжтой болго. Ингэснээр хүүхдүүд ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэхэд дөхөм болно.

Үг харахад энд дар.

2 дахь долоо хоног : Есүс Христ сайныг үйлдэж явсан

Ойлголтыг чухалчил: Хүүхдүүдэд хос ширэн углааш үзүүл (эсвэл Есүсийн углааш өмссөн зургийг үзүүл). Есүс ийм гутал өмсч хөөд сайныг үйлдэж явсан гэдгийг тайлбарлан хэл. Дараах өгүүлбэрийг самбар дээр бич: “Тэр сайныг үйлдэж явсан, учир нь Бурхан Түүнтэй хамт байсан” (Үйлс 10:38). Энэ өгүүлбэрийг тантай хамт давтан хэлэхийг хүүхдүүдээс хүс. Дараах үйл явдлыг харуулсан зургуудыг өрөөг тойруулан тавь: Есүс хүүхдүүдийг адисалж буй нь (3 Нифай 17:21–24), Есүс хараагүй хүнийг эдгээж байгаа нь

(Иохан 9:1–17), Есүс Жайрусын охиныг үхлээс амилуулсан нь (Матай 9:18–19, 23–25), мөн Есүс 5000 хүнийг хооллосон нь (Иохан 6:5–14). Тэр углаашийг өмсөж буй дүр эсгээд тэднийг нэг зураг дээр очихыг хүс. Есүс зураг дээр юу хийж байгааг тодорхойлохыг хэд хэдэн хүүхдээс хүс. Дараагийн зураг уруу алхахаас өмнө тэднээс “Тэр сайныг үйлдэж явсан, учир нь Бурхан Түүнтэй хамт байсан” гэсэн өгүүлбэрийг давтан хэлэхэд урь. Зураг бүр дээр давт.

3 ба 4 дэх долоо хоног: Есүс Христийн үлгэр дуурайл нь надад хэрхэн амьдрахыг заадаг

Ойлголтыг чухалчил: Самбар дээр дараалалгүйгээр хоёр жагсаалт гарга—нэг нь бидний дагах ёстой Есүсийн үлгэр дуурайл мөн эдгээр судруудтай холбоотой нэг нэг дууг бич. Хүүхдүүдийг хэд хэдэн баг болго. Таны жагсааж бичсэн судруудын үйл явдлыг харуулсан зургуудаас нэгийг баг тус бүрд тарааж өг. Самбар дээр бичсэн дуу болоод судрын хэсгийг авсан зургийнхаа утга санаатай тохируул. Баг тус бүрийг ээлжээр зургаа үзүүлэн, Есүсийн үзүүлсэн үлгэр дуурайлыг тайлбарлаж мөн дууг дуулахад удирдан дуулуул. Дараах дуунуудыг ашиглаж болно:

- Есүс хүү Ариун Сүмд, Лук 2:42–49, “Их Эзэнийг эрэлхийл” (ХДН, 108)
- Иохан Баптист Есүст баптисм хүртээж байгаа нь, Матай 3:13–17, “Баптисм” (ХДН, 100–101)
- Тиймээс явагтун, Матай 28:19–20, “Бид үнэнийг энэ дэлхийд авчирна” (ХДН, 172–173)
- Есүс Нифайчуудыг эдгээж байгаа нь, 3 Нифай 17:7–9, “Би чамтай хамт алхах болно” (ХДН, 140–141)



Есүс Христ бол бидний дагах цорын ганц төгс жишээ юм гэдгийг гэрчил.

Ойлголтыг чухалчил: Цаасаар зүрх хайчлаад үүн дээрээ *Бие биеэ хайрла гэж бичнэ* үү.

Үүнийг судрынхаа завсар хий, Иохан 13:34. Нэг хүүхдийг урьж судрынхаа завсраас нөгөө зүрхийг олохыг хүс. Энэ судрын хэсэгт Есүс бидэнд бусдад хэрхэн хандах талаар заадаг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг өөрсдийнхөө судраас Иохан 13:34-ийг олоод уншихыг хүс. Боломжтой бол хүүхэд бүрд цаасан зүрх өгөөд, судрынхаа завсар хавчуулаад гэр бүлийнхэнтэйгээ энэ үйл ажиллагааг хийхийг хүс.

Хэрэгжүүлэлтийг чухалчил:

Хүүхдүүдийн тооноос хамаараад нэг эсвэл хоёр тойрог болгон зогсоо (Хэрэв хангалттай зай байхгүй бол нэг эгнээний хүүхдүүдийг арынхаа эгнээний хүүхдүүд рүү сандлаа эргүүлэн харуулж сууж болно). Баг тус бүрд товч сүвлэн, хоёр үзүүрийг нь холбон зангидсан урт утас өг. “Бие биеэ хайрла” дууг дуулж байхдаа (ХДН, 136), товчийг гулсуулан дамжуул. Хөгжмийг гэнэт зогсоож, товчийг барьж байгаа хүүхдээс бусдыг хайрлаж байгаагаа үзүүлэх нэг арга замыг хэлэхийг хүс. Бусад хүмүүс тэднийг хайрлаж байгаагаа хэрхэн үзүүлдгийг хуваалцахыг хүүхдүүдээс хүс.




Хөгжмийн удирдаачид зориулсан тусламж

Хүүхдүүдэд “Намайг дага” (Сүмийн дуулал, 116) дууг сурахад нь дөхөм болох үүднээс дараах зүйлсийг анхаарна уу:

- Таны хийсэн үйлдлийг дагаж хийхийг хүүхдүүдээс хүс. Та хамартаа хүрч, гар барьж, эсвэл гараа урдаа зөрүүлж болно. Бид Есүсийн хийж байсан зүйлсийг дагаж хийснээр Түүнийг дагаж болно гэдгийг тэдэнд хэл. Дууны хөгжмийг тоглож байх зуур хүүхдүүд хоёр хуруугаараа нөгөө

гарынхаа алган дээр цохиж дууны ритмыг хийнэ.

- Цаасаар хөлийн мөр хайчилж дээр нь дууны үгнүүдээс бич. Хөлийн мөрнүүдийг самбар дээр нэг нэгээр нь тавихыг хүс. Энэ зуур та дууг дуулж, хүүхдүүд үгсийг давтан хэлнэ. Хөлийн мөрнүүдийг явсаар байгаад Есүсийн зураг уруу очихоор зохицуулан тавь.



Хөлийн мөр энд дар.

Дууны удирдаач нь хүүхдүүдэд дуунаас сургаалыг сурахад туслах хэрэгтэй. Хүүхдүүд дууны үгс, хөгжим болон үзүүлэн материалыг хооронд нь уялдуулан сурч болно. Дараагийн хэдэн долоо хоногийн туршид хүүхдүүд дууг суртлаа хөлийн мөрнүүдийг ашиглаж болно.

Есүс Христ бол Бурханы Хүү, мөн Тэр бол гайхамшгуудын Бурхан билээ

Хүүхдийн дууны ном оос хүссэн дуугаа сонгон дуул.

Зөвлөмж: Хүүхдүүд хийх тусмаа сайн сурдаг. Түүх ярихдаа үйлдлийг нь хийхийг хүүхдүүдээс хүс. Түүхийг ярихаасаа өмнө хөдөлгөөнүүдийг давтаж бэлд. Энэ нь таныг түүх ярьж байхад хүүхдүүд анхаарлаа илүү төвлөрүүлж сонсох боломжийг олгодог.



Хэд хэдэн баг болгон хуваах нь

Олон баг болгон хувааснаар илүү олон хүүхдийг сурах үйл явцад татан оруулах боломжтой. Хуваалцах цагт хүүхдүүд анги ангиараа хамт суудаг. Энэ ангиудыг жижиг хэсгээр хуваах үйл ажиллагаанд оролцуулж болно.

“Учир нь болгоогтун, би бол Бурхан, мөн би бол гайхамшгуудын Бурхан; . . . мөн тэдний итгэлийн дагуу байхаас бусдаар би хүмүүний үрсийн дунд ажиллах нь үгүй” 2 Нифай 27:23).

Энд дурдах санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би Ариун Сүнснийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

1 дэх долоо хоног: Есүс Христ бол гайхамшгуудын Бурхан

Сургаалыг таньж мэд: Самбар дээр есөн жижиг дөрвөлжин зур. Энэ үг нь *гайхамшиг*. Хүүхдүүдээс үгийг таахыг хүс. Эхний үсгийг бичээд хүүхдүүдээс үгийг таахыг хүс. Хоёр дахь үсгийг бич. Хүүхдүүдийг таатал нь дараагийн үсгийг бичээд таахыг хүс. Гайхамшиг гэдэг бол Бурханы хүчээр бий болгогдсон ер бусын үйл явдал юм гэдгийг хүүхдүүдэд тайлбарлан хэл. Хүүхдүүдийг хэд хэдэн баг болго. Баг тус бүрд хайчилсан дараах үгсийг өг: *гайхамшигүүд, харуулах, Есүс Христ, хүч чадалтай, дээр, дэлхий*. Баг тус бүр энэ үгсээр өгүүлбэр зохионо.


[Үг харахад энд дар.](#)

Ойлголтыг чухалчил: Өөрийнхөө үгээр, Есүс шуургыг намжааж, (Марк 4:36–39) загасчдын торыг загасаар дүүргэсэн түүхийг тэдэнтэй хуваалц (Лук 5:1–11). Түүхүүдийг жүжигчлэн (салхи, усны давалгааг биеэрээ дүрсэлж, хоосон болон дүүрэн тор татаж байгаа мэт бол) үзүүлэхийг хүүхдүүдээс хүс. Энэ хоёр түүх нь хоёулаа Есүс Христ дэлхийг захирах хүч чадалтай гэдгийг харуулж байгааг тус тусад нь гэрчлэн хэл. Эдгээр гайхамшгууд нь үнэхээр хэрэгцээтэй байгаа хүмүүст хэрхэн тус болж байгааг харуулсан талаар хүүхдүүдээр яриул.

2 дахь долоо хоног: Есүс Христ өвчтэйг эдгээж чадна

Ойлголтыг чухалчил: Хүүхдүүдийг баг болго. Анги тус бүрийн багш нараас сударт гардаг, Есүс хэн нэгнийг эдгээсэн түүхүүдээс аль нэгийг унших юмуу ярьж өгөхийг хүс. Хоёр сохор хүнийг эдгээж буй түүх гэх мэт. (Матай 9:27–31), өвчтэй эр (Иохан 5:1–9), уяман өвчтэй арван хүн (Лук 17:12–19), эсвэл түшмэлийн хүү (Иохан 4:46–53). Түүхийг

дүрслэн зуруул. Хэд хэдэн хүүхдийг зурсан зураг болон түүхийг Хүүхдийн хэсгийн хүүхдүүдтэй хуваалцахад урь. Хүүхдүүд түүхийг хуваалцаж байх зуур Есүсийн эдгээсэн хүмүүст ямар сэтгэгдэл төрж байсныг төсөөлөхийг хүс. Хүүхдүүдэд зурсан зургаа гэрийхэндээ үзүүлэхийг сануул.



3 дахь долоо хоног: Есүс Христ үхлийг дийлэх хүч чадалтай

Ойлголтыг чухалчил: Хэсгийнхээ гишүүдийг Хүүхдийн хэсэгт ирж дараах үйл явдлуудын гэрч байсан мэтээр товчхон түүхийг нь ярьж өгөхөд урь: Лазарыг амилуулсан (Иохан 11:1–45); Жайрусын охиныг амилуулсан (Марк 5:21–24, 35–43); бэлэвсэн эмэгтэйн хүүг амилуулсан (Лук 7:11–16); мөн

Амидуулалт (Иохан 20:1–18). Уригдсан зочид энгийн толгойн ороолт ороож эсвэл нөмрөг нөмөрч болох юм. Есүс Христ үхлийг ялан дийлэх хүч чадалтай, мөн бид бүгдээрээ амилуулагдах болно гэдгийг гэрчлэхийг тэднээс урьдчилж хүсээрэй.



Долоо хоног 4: Итгэлтэй хүмүүст гайхамшиг тохиодог

Сургаалыг таньж мэд: Самбар дээр Сургаал ба Гэрээ 63:9; “Гэвч, болгоогтун, итгэл тэмдгүүдээр ирдэггүй, харин итгэдэг тэднийг тэмдгүүд дагалддаг буюу” хэмээн бич. Тэдэнд тэмдгүүд гэдэг нь мөн *гайхамшиг гэсэн үг болохыг тайлбарла*. Хүүхдүүдийг босоод судрын хэсгийг чангаар уншихыг хүс. *Итгэл хэмээх үгийг онцгойлон тодорхойл*.

Гайхамшиг гэхээр л дандаа заавал сүржин үйл явдлыг хэлэхгүй бөгөөд бид ямагт эхлээд итгэлтэй байх хэрэгтэй, тэгснээр бид амьдралдаа тохиох гайхамшгуудыг таних болно. Бид хэдий итгэлтэй ч бидэнд уйтгар гуниг, өвчин зовлон тохиолдоно. Гэвч Бурхан бидний хэрэгцээ шаардлагыг мэддэг болохоор анхааран халамжлах болно.

Ойлголтыг чухалчил: Мосе Бурханы хүмүүсийг Египет уруу явуулахыг зөвшөөрөхийг Фараонаас асуудаг түүхийг өөрийн үгээр хүүхдүүдэд ярьж өг (Египетээс гарсан нь 7–10). Түүхийг ярьж эхлэхээсээ өмнө зарим зовлон зүдгүүрийг төлөөлөх дуу чимээ эсвэл үйлдлийг хүүхдүүд давтахад урь. Жишээлбэл: Хүүхдүүд гараа давалгаалж буй мэт хөдөлгөж, голын дуу чимээ гаргаж, бөөстсөн мэт бүх биеэ маажиж, үхэр шиг мөөрч, ууртай байгаа мэт дуугарч болно. Таныг түүхийг ярьж

байхад анхааралтай сонсохыг хүүхдүүдээс хүс. Та түүхийг ярьж байхдаа гараа өргөвөл ямар зовлон зүдгүүрийн талаар ярьсныг төлөөлөх дуу чимээ, үйлдлийг хүүхдүүд үзүүлж, та гараа буулгахад тэд зогсох ёстой. Зовлон зүдгүүр бүрийг хэлснийхээ дараа Фараон энэ бүх зүйл тохиолдсон ч хүмүүсийг явуулаагүй гэдгийг тайлбарла. Фараон олон гайхамшиг хийгээд тэмдгүүдийг харсан боловч тэр Бурханд итгээгүй. Энэ түүхээс эсрэгээр итгэл хэрхэн гайхамшгуудыг бий болгосон тухай түүх ярь (жишээлбэл: Элайжа, Зарэфатын бэлэвсэн эхнэр, Даниел ба арслангууд, Жаредын ах эсвэл Нифай, Лихай нар шоронд байсан тухай). Хэрэв цаг байвал түүхтэй хамт хийж болох үйлдлүүд зохиохыг хүүхдүүдээс хүс.

Хэрэгжүүлэлтийг чухалчил: Нэг юмуу хоёр гэр бүлийг Есүс Христэд итгэлтэй байснаар гайхамшгууд хэрхэн амьдралнь адисалсан талаар хуваалцуулахаар урь. (Гэр бүлүүдэд бэлтгэх хангалттай цаг өгөх үүднээс урьдчилж урь.) Бид итгэлтэй байвал амьдралдаа гайхамшгуудыг үзэх болно гэдгийг гэрчил.

Зөвлөмж: *Хүүхдийн хэсэгт сурсан зүйлсээ бусадтай хуваалцах нь тэдний сургаалын талаарх ойлголт болон гэрчлэлийг бэхжүүлдэг. 2 дахь долоо хоногт тэднийг сурсан зүйлсээ гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахыг урьсан. Энэ нь тухайн гэр бүлд сайн мэдээний талаар яриа өрнөж, тэгснээр гэр бүлийг нь бэхжүүлэх болно.*

Ойлголтыг чухалчлах нь

Хүүхдүүд судрын түүхүүдийг хөдөлгөөнөөр илэрхийлснээр тэд түүхийг санаж мөн илүү сайн ойлгодог.



Би Есүс Христэд хайртай учраас Түүнийг дуулгавартай дагадаг

*“Хэрэв та нар Намайг хайрладаг бол Миний тушаалуудыг сахь”
(Иохан 14:15).*

Энд дурдах санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би Ариун Сүнсийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

Зөвлөмж: Судруудыг цээжлэх нь хүүхдүүдэд сайн мэдээний сургаалыг суралцахад нь тус болдог. Судруудын үгс нь тайвширал болоод удирдамжийн эх үүсвэр болж чаддаг (TNGC, 171). 1 дэх долоо хоногт судар цээжлэхэд дөхөм болох гурван зүйлийг хэлсэн. Үүнд: олон давталт, богино хэллэг болгон хуваах болон үзүүлэн.


1 ба 2 дахь долоо хоног: Би тушаалуудыг сахиснаар Есүс Христийг хайрлаж буйгаа харуулдаг

Сургаалыг таньж мэд: Хүүхдүүдэд Иохан 14:15-ыг, цээжлэхэд нь туслахын тулд зүрх болон Арван тушаалуудыг төлөөлсөн зураг зур. Хүүхдүүдийг хоёр баг болго. Зүрхтэй зургийг нэг багийг хүүхдүүдийн өмнө харуулж зогсоогоод “Хэрэв та нар намайг хайрладаг бол” гэж хэлүүл. Арван тушаалыг төлөөлсөн зургийг нөгөө хүүхдүүдийн өмнө дээш өргөн “Миний тушаалуудыг сахь” хэмээн хэлэхийг хүс. Хэд хэдэн удаа давт. Арай том хүүхдүүд нь Иохан 14:21 (“Миний тушаалуудыг сахьдаг хүн Намайг хайрлагч мөн”)–ийн эхний хэсгийн мөн ижил арга замаар сурч боно.

Ойлголтыг чухалчил: Тушаал бүрийг нэг нэг жижиг цаасан дээр бичиж бэлтгэ (судруудыг унш, зохистой даруу хувцаслах болон Мэргэн ухааны үгийг дуулгавартай дагах зэрэг байж болно). Цааснуудыг саванд хийгээд нэг хүүхдээр нэгийг сугалуулан, гаргаж ирсэн тушаалыг хэрхэн сахихыг үйлдлээр үзүүлэхийг хүс. Харин бусад хүүхдүүд тухайн хүүхдийн юу хийж байгааг таах хэрэгтэй.

“Тушаалуудыг сахь” (ХДН, 146–147) дууг дуул. Дууг дуулж байх зуур тушаалыг хэрхэн сахихыг нэг хүүхэд үйл хөдлөлөөрөө ангийнханд үзүүлэн, бусад нь даган хийнэ. Тухайн тушаалыг сахиснаар тэд хэрхэн адислагдахыг хэлэх хэд хэдэн хүүхдийг урь.

Хэрэгжүүлэлтийг чухалчил: “Миний сайн мэдээний жишгүүд”–ийг хүүхдүүдтэй хамтдаа ярилц. Эдгээр жишгийг дагаж мөрсөнөөр бид Есүс Христийг хайрлах хайраа харуулж байгаа хэрэг юм гэдгийг тайлбарла. Дараах судруудын эшлэлүүдийг тус тусад нь цаасан дээр бич: Египетээс гарсан нь 20:7; Египетээс гарсан нь 20:8–10; Египетээс гарсан нь 20:12; Иохан 13:34–35; Мозая 18:10; мөн Сургаал ба Гэрээ 42:40–41. Хүүхдүүдийг хэд хэдэн баг болгон хуваагаад, багуудад хамтдаа унших судрын хэсгийг өг. Судрын эшлэлээ сайн мэдээний аль нэг жишигтэй нь тохируулаад тэр жишгийн дагуу тэд хэрхэн амьдрахыг ярилц. Хүүхдүүдээс өөрсдийн бодол санаагаа Хүүхдийн хэсгийн бусад хүүхдүүдтэй хуваалцахыг хүс.



[Зураг энд дар.](#)

Судруудыг цээжлэх

Дүрслэлийг хараад, судруудыг давтан хэлэх нь хүүхдүүдэд судрыг цээжлэхэд тусална.



3 дахь долоо хоног: Залбирснаар Есүс Христийг хайрлах хайр минь өсдөг

Ойлголтыг чухалчил: Хүүхдүүдийг хэдэн баг болгон хуваа. Баг тус бүрийг дараах судруудыг уншин ярилцахыг хүс. Уншиж байхдаа Аврагч залбирлын талаар юу заасныг эрэлхийл. 3 Нифай 18:19–20; Сургаал ба Гэрээ 19:28, 38; 88:63–64. Аврагч бидэнд Өөрийнхөө нэрээр Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахыг заасан бөгөөд ингэснээр энэ нь биднийг Түүнтэй илүү ойр гэдгээ мэдрэхэд маань тусалдаг гэдгийг онцол.

Ойлголтыг чухалчил: *Бяцхан үрсээ бол-гоогтун* Балчир хүүхдийн ангийн гарын авлагын 19-р хуудасны зургийг хүүхэд бүрд өг. Зургийг өнгөөр ялган будуулж, будсан зургаа авч яваад гэр бүлийнхэндээ үзүүлэхийг хүс.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг чухалчил: Залбирлын тухай дуу ХДН-с дуул. “Хүүхдийн залбирал” (ХДН, 12–13)



эсвэл “Бид толгойгоо бөхийлгөнө” (ХДН, 25) гэх мэт. Залбирах үед Их Эзэнийг хайрлах хайр тань хэрхэн өсдөг талаар хүүхдүүдтэй ярилц. Самбар дээр дөрвөн баганатай хүснэгт зур. Эхний багананы дээд талд *Бидний Тэнгэрлэг Эцэг* хэмээн бич. Хоёр дахь багананы дээд талд *адислалууд өгсөнд Түүнд таларх* гэж бич. Гурав дахь багананы дээд талд *Түүнээс хүсэх адислалууд* гэж бич. Дөрөв дэх багананы дээд талд *Есүс Христийн нэрээр*, амен хэмээн бичнэ үү. Анги ангиараа талархаж явдаг адислалуудынхаа талаар ярилцаад жагсаалт хийхийг хүс. Тэгээд баг тус бүрийг талархаж явдаг нэг нэг адислал хэлэхийг хүсэж 2 дахь багананд бич. Дараа нь анги тус бүрдээ Тэнгэрлэг Эцэгээс гуйх адислалуудын талаар ярилцаж жагсаалт хийхийг хүсээд 3 дахь багананд бич. Залбирлын бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар ярилц.

Өнгөөр ялгаж будах үйл ажиллагаа

Бүх хүүхэд өнгөөр ялгаж будах дуртай байдаггүй. Зарим нь хуудсан дээр ганиц хоёр зураас татаж ч магадгүй. Өнгөөр ялган будахын гол зорилго нь сурсан зүйлийг нь төлөөлөх биет зүйл болж хүүхдүүд гэртээ авч харихад оршино.

4 дэх долоо хоног: Судруудаас суралцсанаар Есүс Христийг хайрлах хайр минь өсдөг

Ойлголтыг чухалчил: Христ хүмүүсийг эдгээн адисалж байгаа түүхийг ярь; 3 Нифай 17:7, 9–12, 20–24, эсвэл том хүүхдүүдийг судраас уншихыг хүс. Тухайн түүхээс сэдэвлэсэн зураг зуруул. Судраас уншсанаар Есүс Христийг хайрлах хайр тань хэрхэн өссөнийг гэрчил.

Хэрэгжүүлэлтийг чухалчил: “Их Эзэнийг эрэлхийл” (ХДН, 108) дууг дуул. Судруудыг унших юмуу сонссоноор хүүхдүүд Есүс Христийн талаар илүү ихийг сурч

болохыг ойлгуул. Тэгээд тэдэнд хүүхдүүдийг адисалж байгаа Есүсийн түүхийг ярьж өг Марк 10:13–16. Есүс бяцхан хүүхдүүдийг адисалж буй зургийг үзүүл. Хэрэв тэд тэнд байсан бол ямар санагдах байсныг төсөөлөхийг хүүхдүүдээс хүс. Хэдэн хүүхдээс сэтгэгдлээ хуваалцахыг хүс. Хүүхдүүдэд Есүсийн тухай судраас уншсанаар тэд Аврагчтай илүү ойрхон байгаа мэт мэдрэмжтэй байх болно гэдгийг тайлбарлан хэл.



Зөвлөмж: *Хуваалцах цагаа бага насны болон том хүүхэд бүгдийг оролцуулахаар төлөвлө. Жишээлбэл: 3 дахь долоо хоногийн эхний үйл ажиллагаа томхон хүүхдүүдэд тохиромжтой байсан бол хоёр дахь үйл ажиллагаа нь бага насны хүүхдүүдэд илүү тохиромжтой байсан.*

Зөвлөмж: *Сургаалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар хуваалцах нь хүүхдүүдийн зурх сэтгэлд буй сургаалыг баталгаажуулж, Сүнсийг урьдаг. Сургаал заасныхаа дараагаар үүнийг хэрхэн амьдралдаа хэрэгжүүлэх талаар сэтгэгдлээ хуваалцах боломжийг хүүхдүүдэд олго.*

Сүмийн үүрэг бол бүх хүнийг Христэд ирэхэд урих

*“Тиймээ Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн”
(Моронай 10:32).*

Зөвлөмж: Хэрэв та зураг болон бусад үзүүлэх материал ашиглавал хүүхдүүд илүү сайн сурч, удаан мартаж болно (TNGC, 176, 182–183). Хүүхдүүд өөрсдөө үр дүнтэй, сайн оролцуулж болох дүрүүдийг бүтээж чаддаг. Бүрэн цагийн нэг номлогчийг Хүүхдийн хэсэгт урих эсвэл номлогч шиг хувцасласан хүүхдийг урих нь зураг тавихаас илүү дээр юм.



Давталтаар сурах

Хүүхдүүд давталт, сорилтоор их юм сурдаг. Энд хүүхдүүд судрын эшлэлийг унших бөгөөд үгсийг дарааллын дагуу тавих сорилтонд оролцуул.

Энд дурдсан санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би Ариун Сүнснийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

1 дэх долоо хоног: Бошиглогчдыг дагах нь Христэд ирэхэд бидэнд тусална

Сургаалыг таньж мэд: Хүүхдүүдийг босоод Сургаал ба Гэрээ 1:38-ыг чангаар уншихыг хүс. Бошиглогчид бол Есүс Христийн үйлчлэгчид юм гэдгийг тайлбарла. Есүс Христ болон одоогийн бошиглогчийн зургийг үзүүлээд бид бошиглогчийг дагаж байна гэдэг нь Есүс Христийг дагаж байна гэсэн үг гэдгийг хүүхдүүдэд хэл.

Хэрэгжүүлэлтийг чухалчил:

“Бошиглогчийг дага” дууны 9 дэх бадгийг дуул (ХДН, 110–111). Хүүхдүүдийг баг болгон хуваагаад ерөнхий чуулганы үеэр амьд бошиглогчид, төлөөлөгчдөөс сурсан нэг, хоёр зүйлээ сонгохыг хүс. Нэг багийг сурсан зүйлээ жүжигчлэн үзүүлэхийг хүс. Харин нөгөө багийг тэдний юу хийж байгааг таалга. Баг тус бүрээр ээлжлүүлэн хийлгээд, ээлжээ солих хооронд нь “Бошиглогчийг дага” дууны дахилтыг дуул.

2 дахь долоо хоног: Сургаалыг хуваалцах нь бусдад Христэд ирэхэд нь тусалдаг

Сургаалыг таньж мэд: Бүрэн цагийн номлогчийн зургийг самбар дээр тавь. Тэд номлолын ажлын талаар зарим нэг судрын эшлэл унших болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Ангийн хэсэг хүүхдүүдээс Матай 28:19–20-ийг, харин нөгөө хэсгээс Сургаал ба Гэрээ 133:37-г уншихыг хүс. Тэднийг уншсан

судрын эшлэлээсээ номлолын ажлын талаар юу сурснаа хуваалцаж, Хүүхдийн хэсгийн бүх хүүхдүүдтэй ярилцахад урь. Гэр бүлийн гишүүдээс нь номлолд үйлчилж байгаа хүүхдээс номлолын ажлын талаар сэтгэгдлээ хуваалцахыг хүс.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг чухалчил:

Хүүхдүүдийг босоод “Тэд намайг номлолд дуудна гэж найдаж байна” (ХДН, 169) дууг дуулахыг хүс. Тэнгэрлэг Эцэг сайн мэдээг дэлхий даяар заалгах хүсэлтэй байдаг бөгөөд хүүхдүүд одооноос номлогч болохоор бэлтгэх хэрэгтэйг сануул. Нэг саванд тэднийг номлолд үйлчлэхээр бэлтгэхийг сануулах зүйлсийг хийж тавь. Үүнд: судрууд, аравны нэгийн дугтуй, цаасан зүрх зэргийг хийж болно. Нэг хүүхдийг савнаас нэг эд зүйл гаргаж ирээд үүний төлөөлж буй зүйлийг хийх нь тэднийг номлолд бэлтгэхэд нь хэрхэн туслах талаар хуваалцуул.



Үг харахад энд дар.

3 дахь долоо хоног: Алдаа хийсэн үедээ наманчилснаар бид Христэд ирдэг

Сургаалыг таньж мэд: Есүс Христийн зургийг самбар дээр тавь. Хүүхдүүдийг “Тиймээ, Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн” (Моронай 10:32) хэсгийг цээжлэхэд нь тусал. Судрын эшлэлийн үг бүрийг тус тусад нь цаасан дээр бич. Цаасыг холилдуулан замбараагүй тавь. Хүүхдүүдийг судрын эшлэлийг олж тантай хамт уншихад урь. Сударт өгүүлж буйгаар нь эхний үгийг олоод самбар дээр дарааллын дагуу тавь. Судрыг дахин уншаад дараагийн үгийг олохыг өөр нэг хүүхдээс хүс. Өгүүлбэр зөв байрлалдаа ортол үргэлжлүүлэн хий. Христэд ирнэ гэдэг нь Түүнд итгэлтэй байж, Түүний тушаалуудыг сахиж, алдаа хийсэн үедээ наманчлахыг хэлдэг гэдгийг хүүхдүүдэд тайлбарлаж хэл.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг

чухалчил: Есүс Христийн Цагаатгалын ачаар бид ямар нэгэн алдаа гэм хийсэн үедээ наманчлах боломжтой болсон. Дөрвөн ширхэг хөлийн мөр цаасаар хайчил. Тэгээд тус бүр дээр нь наманчлалын алхмуудыг бич: (1) гэмших, (2) уучлал өршөөл эрэх, (3) алдаагаа засах болон (4) алдаагаа дахин давтахгүй байх. Хөлийн мөрнүүдийг Есүс Христийн зураг уруу хөтлөхөөр газар цувуулан тавь. Хүүхдүүдийг баг болгоод тус бүрд нь нэг хүүхдийн наманчлах ёстой хэрэг хийсэн байдлыг төсөөлөн ярь. Жишээлбэл: “нэг хүүхэд гэртээ бөмбөг өшиглөн эцэг эхдээ дуулгаваргүй байснаар ямар нэг юм эвдчихэв.” Наманчлалын алхам бүрийг хэрэгжүүлэн тухайн хүүхэд юу хийх хэрэгтэйг тэднээс асууж, хоорондоо ярилцахыг хүс.



Хөлийн мөр энд дар.

Хэрэгжүүлэлтийг чухалчил

Сайн мэдээний зарчмуудыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар үзүүлэхдээ хүүхдүүд их юм сурч авдаг.

4 дэх долоо хоног: Ариун Сүмийн ажил нь намайг болон гэр бүлийг маань Христэд ирэхэд тусална

Ойлголтыг чухалчил: “Би Ариун Сүм харах дуртай” дууны хоёр дахь бадгийг заа (ХДН, 95). Найман хэсэг цаасны ард нэг ариун сүмийн зургийг үзүүл. Цаас бүр дээр доорхын аль нэгийг зур: зүрх, нээлттэй хаалга, гэрээ, дуулгавартай байх, ариун газар, лацлагдсан гэх үгс, хүүхдийн болон нэгэн гэр бүлийн зураг. Эдгээр нь нэгэн дууны түлхүүр үгс юм гэдгийг хэл. Тухайн дууны нэг мөрийг та дуулж хүүхдүүдийг анхааралтай сонсоход урь. Аль түлхүүр үг нь тэр мөртэй нийцэж байгааг асууж, хүүхдийг тэр цаасыг авахад урь. Саяны мөрийг хүүхдүүдтэй дахин дуул, тэгээд энэ нь ямар утгатайг тайлбарла. Тухайн мөрний утга санааг үйлдлээр илэрхийлэн ярихад урьж

болно. Дууны мөр бүрд үүнчлэн хий. Зургийг бүрэн ил гаргасны дараагаар дууг бүхэлд нь үйл хөдлөлтэй дуул. Том болохоороо ариун сүмд орохуйц зохистой байхын төлөө тэд одооноос бэлтгэж эхлэх хэрэгтэй бөгөөд энэ нь тэднийг Есүс Христэд ойр аваачна гэдгийг хүүхдүүдэд хэл.



Гар урлал энд дар.

Зөвлөмж: Нөхцөл байдалд шинжилгээ хийнэ гэдэг нь адилхан нөхцөл байдалд орсон үед юу хийх вэ гэдгийг ярилцах бодит амьдралд ойр нөхцөлүүд билээ (3 дахь долоо хоног хар). Нөхцөл байдлын шинжилгээ нь сайн мэдээний зарчмуудыг хэрхэн амьдралдаа хэрэгжүүлж болохыг харуулдаг (TNGC, 161–162).



Зөвлөмж: “Зааж буй тэдэндээ хайраа үзүүлэх нь тэднийг Сүнсэнд илүү дуулгавартай болгодог” (TNGC, 31). Хүүхдүүдийн төлөө нэг бүрчлэн залбирснаар, тэдний хүсэл сонирхол, асуудлуудыг мэдсэнээр, тэднийг нэрээр нь дуудаж, анхааралтай сонссоноор хүүхдүүдийг хайрлах хайр тань өсөх болно.

Бусдад үйлчилж байгаа нь бид Бурханд үйлчилж байна гэсэн үг

“Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу” (Мозая 2:17).

Энд дурдах санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би Ариун Сүнснийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

1 ба 2 дахь долоо хоног: Есүс Христ бусдад хэрхэн үйлчлэхийг бидэнд заасан

Ойлголтыг чухалчил: Нэгэн өдөр Есүсээс нэг хүн “Хэн миний хөрш юм бэ?” хэмээн асуув. Есүс бусдад хэрхэн үйлчлэх талаар түүх ярьж түүний асуултад хариулсан. Хэдэн хүүхдийг сайн санаат Самари хүний тухай түүх дээр гардаг шиг дараах зүйлийг төлөөлүүлэн хувцасла: аялагч, хэдэн хулгайч дээрэмчид болон дэн буудлын эзэн. Түүхийг өөрийн үгээр ярьж өг (Лук 10:30–37) тэгээд хүүхдүүдийг жүжигчлэн үзүүлэхэд нь тусал. “Бидний хөрш гэж хэн болохыг энэ түүхэнд юу гэж зааж байна вэ? хэмээн асуу. Бид хэнд үйлчлэх вэ?” Бидний хөрш гэдэг нь тусламж хэрэгтэй хүн бүхэн юм гэдгийг онцгойлон хэлж өгөөрэй. Хүүхдүүд найз нөхөд, гэр бүлийнхэндээ үргэлж үйлчилж тусалж байх хэрэгтэй ч, өөрсдийн танихгүй хүмүүст үйлчлэхдээ зөвхөн эцэг эх эсвэл найдвартай, насанд хүрсэн хүний хараа хяналтан дор туслах ёстойг тайлбарлана уу. Есүс

Христ бүх хүмүүст хайртай, мөн биднийг бүх хүмүүст үйлчлэхийг хүсдэг гэдгийг гэрчил.

Хэрэгжүүлэлтийг чухалчил: Есүс биднийг бусдад үйлчлэхийг хүсдэг, үүнд гэр бүлийн гишүүд маань ч багтана. Цаасаар хэдэн жижиг дугуй дүрс хайчлаад хэдэн хүүхдэд өг. Тэднийг дугуй дотор инээж буй царай зурж “Инээмсэглэлт үйлчлэл” хийхийг хүс. Ирэх долоо хоногийн туршид гэр бүлийнхээ гишүүдэд жижиг ч гэсэн үйлчлэл хийхийг хүүхдүүдээс хүс. Хийж болох үйлчлэлийн талаар бүгдээрээ хамтдаа ярилц (ээлдэг зүйл бичиж үлдээх, тоглоомоо хураах, орыг нь засах зэрэг байж болно). Үйлчлэл хийсэн газраа “Инээмсэглэлт үйлчлэл” үлдээ гэж хүүхдүүдэд хэл. Гэр бүлийнхээ гишүүдийг энэ үйл ажиллагаанд тэдэнтэй хамт оролцохыг урь гэж хүүхдүүдэд хэл.



Дараагийн долоо хоногт тэдний хийсэн үйлчлэл гэр бүлийн гишүүдэд нь хэрхэн инээмсэглэл авчирсныг Хүүхдийн хэсэг дээрээ хуваалцахыг хүс.

Судруудын түүхийг дүрслэн үзүүлэх

Өдөр тутмын энгийн эд зүйлсийг ашиглан энэхүү түүхийг дүрслэн үзүүлэх нь хүүхдүүдийг дүрслэн санахад нь дөхөмтэй.



Зөвлөмж: Судрын зарим түүхүүдийг хүүхдүүдийн насанд тохируулан өөрчилж болно. 1 дэх долоо хоногт сайн санаат Самари хүний түүхийг заах үедээ хэрэв хүүхдүүдээс хэн нэгэн танихгүй хүн тусламж хүсвэл эхлээд заавал насанд хүрсэн хүний тусламж хүсэх нь маш чухал гэдгийг онцол.



Зөвлөмж: Хуваалцах цаг нь Бурханд итгэх итгэл хөтөлбөрийг дэмжих боломжуудыг олгодог. 1 болон 2 дахь долоо хоногийн үйлчлэл нь Бурханд итгэх итгэл удирдамжийн 8–9 дүгээр хуудсанд буй зорилгуудыг хэрэгжүүлэх боломжтой.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг

чухалчил: сайн санаат Самари хүний түүхийг өөрсдийнхөө үгээр дахин ярихдаа бэлтгэхийг урь. Тэдэнд сануулахын тулд өмнөх долоо хоногт ашигласан хувцаснуудыг ашиглаж болно. Тэгээд хүүхдүүдэд өнгөрсөн долоо хоногийн “Инээмсэглэлт үйлчлэл”-ийнхээ талаар тайлагнах боломж олго. Энд

үзүүлсэн байгаа шиг дугуйг Хүүхдийн хэсгийн бүх ангиудад хийх нь үүнийг хийх нэг арга зам байж болно. Анги бүрийн дугуйг эргүүлэн нэг эсвэл хоёр хүүхдийг сонгож үйлчлэлийнхээ талаар, энэ нь бусдыг аз жаргалтай байлгахад хэрхэн тэдэнд тусалсан талаар яриул. Цаг байвал үргэлжлүүлэн хий.



[Гар урлал энд дар.](#)

3 дахь долоо хоног: Гэр бүлийнхэндээ үйлчлэх нь Бурханд үйлчилж байгаатай адил

Сургаалыг таньж мэд: “Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа юм” (Мозая 2:17) хэмээн самбар дээр бичээд утга санааг нь яриалц. Хүүхдүүдэд цээжлэхэд нь туслахын тулд судрыг хоёр хуваагаад эхний хэсгийг хэсэг хүүхдүүдээр хэлүүлж (“Та нар бусдадаа үйлчилж байгаа нь”), нөгөө хэсэг хүүхдүүдээр судрын үлдсэн хэсгийг хэлүүд (“та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу”). Хэд хэдэн удаа давт.

Ойлголтыг чухалчил: “Бид тусалж байхдаа” (ХДН, 198), *үйлчилж байхдаа* гэдэг үгийг *тусалж байхдаа гэдэг үгээр орлуулан дуул*. Дууг гэр бүлийн бусад гишүүдийг *ээж* гэдгийн оронд орлуулан дуул (жишээ нь: аав, ах болон эгч гэх мэт). Хүүхдүүдийг дуулж байхдаа гэр

бүлийнхээ гишүүнд ямар үйлчлэл үзүүлэхээ үйлдлээр хийхийг хүүхдүүдээс хүс. Бид үйлчилж байгаа нь Бурханд үйлчилж байгаа гэсэн үг гэдгийг хүүхдүүдэд сануулан хэл.

Хэрэгжүүлэлтийг чухалчил: Самбар дээр цаг зур. Хүүхдүүдийг баг болгон хуваагаад баг тус бүрд өдрийн өөр нэг цагийг даалган өг. Тэд өдрийн аль ч цагт гэр бүлийнхэндээ үйлчилж болно гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэдэнд “Тик ток, тик ток, одоо _____ цаг болж үйлчлэх цаг боллоо!” гэж хэлнэ. Тухайн цаг оноогдсон хэсгийн хүүхдүүдийг босож зогсоод, өдрийн тэр цагт гэрийнхэндээ хэрхэн үйлчлэх арга замыг бусад хүүхдүүдтэй хуваалцахыг хүс. Бүх багт боломж олдтол үргэлжлүүлэн хий.

4 дэх долоо хоног: Би хөршдөө үйлчлэх нь Бурханд үйлчилж байгаа юм

Ойлголтыг чухалчил: Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийг ангид маш туйлдаж ядарсан, үнэхээр тусламж хэрэгтэй байгаа мэт царайлан орж ирэхийг хүс. Жишээ нь: Ерөнхийлөгч хэтэрхий их юм барьчихсан юмаа газар унагаад л эсвэл уйлж байгаа хүүхдийг тайвшруулах гэж ядаж байгаа мэт үйлдэл хийнэ. Хүүхдүүдийг ерөнхийлөгчдөө туслахын тулд өөрсдийн “тусламжийн гар”-аа сунгахыг хүс. Сайн санаат Самари хүний тухай түүхэнд Есүс бидэнд, бусдад тусалж байхыг заасан гэдгийг сануул. Тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийн зураг үзүү. Хүүхдийн хэсгийн гарын авлагын зургийн цомгийг ашиглаж болно. Иймэрхүү тохиолдлуудад хүүхдүүд хэрхэн тусалж болох талаар хуваалцахыг хүс. Эхний хагасыг та давтан хэл Мозая 2:17, тэгээд сүүлийн хэсгийг хүүхдүүдээр давтан хэлүүд.

Ойлголтыг чухалчил: Хүүхдүүдийг цаасан дээр гарынхаа хэлбэрийг зураад дээр нь тэдний гэр бүлийнхэн бусдад үйлчлэх арга

замын талаар бич. Тэднийг гэр бүлийнхэнтэйгээ хамт энэ үйлчлэлийг энэ долоо хоногтоо багтаан хийхийг урамшуул. Гарнуудыг зарлалын самбар дээр тавьснаар хүүхдүүд үйлчлэл хийх тухайгаа үргэлж санах болно.

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг

чухалчил: нэг хүүхдийг ангийн урд гарч ирээд гараа таны гартай харьцуулан үзэхийг хүс. Тэр хүүхдийн гар таныхаас маш жижигхэн болохыг онцгойлон хэл. “Миний том гар тоглоомуудыг цэгцэлж чадна. Та нарын жижиг гар чадах уу?” гэх мэт асуулт асуу. Бүх хүүхдүүдийг хүрч ирэн таны гартай өөрсдийнхөө гарыг харьцуулж үзэхийг хүс. Хэдий тэдний гар жижигхэн ч гэсэн маш олон үйлчлэлийг хийж чадна гэдгийг онцгойлон хэл. “Би хоёр жижигхэн гартай” (ХДН, 272) дууг дуул. Дууг дуулж байхдаа хоёр гараа урдаа зөрүүлэхийг хүс. Тэд *гарнууд* гэдэг үгийг дуулах үедээ хоёр гараа агаарт дээш өргөж, түргэхэн шиг буцаан буулгах хэрэгтэйг хэлээрэй.

Сургаалыг давтан ярилцах

Сургаалыг хөгжилтэй байдлаар хүүхдүүдэд сануулан ярих нь хүүхдүүдийг сурсан зүйлээ эргэн санахад нь тус болно.

Зөвлөмж:

Хүүхдүүдийг олон төрлийн үйл ажиллагаанд оролцуулах нь сурах үйл явцыг илүү хөгжилтэй болгож өгдөг. Хүүхдүүдийг баг болгон хуваахдаа олон янзын арга хэрэглэж болно. Жишээ нь; охид хөвгүүдээр нь, ямар нэг ижил өнгийн хувцас өмсөж буйгаар нь, эсвэл жилийн эхний хагаст ба эцэст төрснөөр нь хувааж болно.

Аврагч минь амьдыг би мэднэ

“Түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа энэ бол Түүний талаар бидний өгөх хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө (С ба Г 76:22).

Энд дурдах санаануудыг өөрөө баяжуулан ашиглаарай. Хүүхдүүд сургаалыг танин мэдэж, ойлгон амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах арга замуудыг төлөвлө. “Суралцахын тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ? Мөн би Ариун Сүнсийг мэдрэхэд нь хэрхэн туслах вэ?” хэмээн өөрөөсөө асуу.

Зөвлөмж: Хүүхдүүдэд харсан зүйл нь илүү тогтдог. Олон төрлийн үзүүлэх материал ашиглах нь зүйтэй. Үүнд: биет эд зүйлс, самбар дээр зурсан зураг, үгийн хайлчилбарууд, картон дээрх зураг, хуруугаа хийж хөдөлгөдөг хүүхэдэй зэрэг байж болно (TNGC, 89–90).

Зөвлөмж: Хүүхдүүд сурсан зүйлсээ бусдад зааснаар түүнийгээ мартажгүй тогтоодог. Тэдэнд хуваалцах цагийн үеэр болон гэртээ заах боломжийг олгоорой.



1 дэх долоо хоног: Бошиглогчдын амласны дагуу Есүс Христ дэлхийд ирсэн

Сургаалыг таньж мэд: Хүүхдүүдээс “Төрсөн өдрөө онцгой байдлаар тэмдэглэсэн үеэ эргэн сана” гэж хүс. Та нар тэр үед юу хийсэн бэ? Хэдэн хүүхдээс төрсөн өдрийнхөө талаар ярихыг хүс. Дэлхийн түүхэнд хамгийн чухал төрөлтийн талаар Тэнгэрлэг Эцэг өөрийн бошиглогчдоороо дамжуулан цаг үеийн эхнээс авахуулан дэлхийд хэлүүсээр ирсэн гэдгийг тайлбарлан хэл. Христ энэ дэлхий дээр ирнэ гэсэн энэ бошиглол нь хэр их чухал байсан нь бошиглогчид өөрсдийн амиа ч золиослох хүсэлтэй байснаас харагдаж байна. “Есүс Христ бошиглогчдын амласны дагуу дэлхий дээр ирсэн” гэдэг өгүүлбэрийг хүүхдүүдээс давтан хэлэхийг хүс.

Ойлголтыг чухалчил: Есүс Христийн ирэлтийн талаар заасан хэд хэдэн бошиглогчдын зургийг үзүүл. Хүүхдүүдийг хэд хэдэн баг болгоод баг тус бүрд бошиглогчдын түүхийг өгүүлсэн судрын эшлэлийг өг. Баг тус бүр түүхийг жүжигчлэн үзүүлж (TNGC, 165–166) Хүүхдийн хэсгийн бусад хүүхдүүдээр ямар бошиглогчийг дүрсэлж байгааг таалга. Тэдгээр бошиглогчид нь Мозая хаан (Мозая 2:1, 5–7; 3:5–8), Абинадай (Мозая 12:1, 9; 15:1–2; 17:1, 8–10), мөн лемен үндэстэн Самуел (Хиламан 14:1–5; 16:1–2) нар байж болно. Есүс Христ үнэхээр дэлхий дээр ирсэн, тиймээс Түүний талаарх бошиглолууд бүгд гүйцэлдсэн гэдгийг гэрчил.

2 дахь долоо хоног: Есүс Христ бол дэлхий ертөнцийн Аврагч мөн

Ойлголт болон хэрэгжүүлэлтийг чухалчил: Дөрвөн ширхэг хайрцгийг бэлэг шиг боож авчир. Хайрцаг бүрд дараах үйл явдлуудаас нэгийг сонгон тухайн үйл явдлыг төлөөлж буй зураг эсвэл эд зүйлс мөн тухайн адислал буюу бэлэгний тайлбарыг бичсэн жижиг цаас хийх хэрэгтэй.

- Үйл явдал: Есүсийн төрөлт, бэлэг: “Тэнгэрлэг Эцэг Өөрийн Цорын Ганц Хүүгээ бидний Аврагч болгохоор өгсөн.”
- Үйл явдал: Уулан дээрх номлол, бэлэг: “Есүс Христ бидэнд хэрхэн зөв шударга амьдрахыг заасан.”
- Үйл явдал: Есүс Гетсеманид залбирсан, бэлэг: “Есүс Христ биднийг нүглээс аврагдах боломжтой болгосон.”

- Үйл явдал: Амилуулалт, бэлэг: “Есүс Христ биднийг амилуулагдах боломжтой болгосон.”

Хүүхдүүдээр бэлгийг задлуулж, бэлэг тус бүр нь биднийг хэрхэн адисалж байгаа талаар ярилц.

Хэрэгжүүлэлтийг чухалчил: Бусдад үйлчлэн мөн тэдэнд хайраа үзүүлэн Аврагчид бэлэг барих арга замуудын талаар ярилц (Матай 25:40). Хүүхэд бүрд цаас өгөөд Аврагчид өгөх нэг бэлэг зурах эсвэл бичихийг тэднээс хүс. Тэгээд цаасаа голоор нь нугалаад гаднаас нь харахад яг бэлэг шиг чимэглэн янзал гэж хэл.

3 дахь долоо хоног: Есүс Христ дэлхий дээр хэзээ нэгэн цагт эргэн ирнэ

Ойлголтыг чухалчил: Есүс Христ дэлхий дээр дахин ирнэ гэсэн агуу мэдээллийн дагуу хүүхдүүд сурвалжлага бэлтгэнэ гэдгийг хэл. Хоёр хүүхдийг телевиз эсвэл сонингийн сурвалжлагчийн дүрд тоглож анги тус бүрээс асуулт асуухыг хүс. Анги тус бүрд дараах асуулт болон судрын эшлэлүүдийг өгөөд хэдэн минут бэлтгэхийг хүс. “Есүс Христийн хоёр дахь ирэлтийн зарим нэгэн тэмдгүүд нь юу вэ? (Иосеф Смит—Матай 1:28–29); Тэр хэрхэн ирэх вэ? (Матай 24:29–31); Тэр хэзээ ирэх вэ? (Матай 24:36, 42, 44); Түүнийг ирэхэд зөв шударга хүмүүст юу тохиолдох вэ? (С ба Г 88:96–97); Түүнийг ирсний дараагаар засгийн газар ямар

байдалтай байх вэ? (Итгэлийн тунхаг 1:10; С ба Г 29:11; 45:58–59); Түүнийг ирсний дараагаар амьтад ямар байдалтай байх вэ? (Исаиа 11:6–9; Хосе 2:18). Сурвалжлагчийн дүрийг бүтээж байгаа хоёр хүүхдийг баг тус бүр асуултаа харуулж дуустал ээлжлэн асуулт асуухыг хүс.

Хэрэгжүүлэлтийг чухалчил: Есүсийн дахин ирэлтэнд бэлтгэх арга замуудын талаар хүүхдүүдтэй ярилц. Хэрэв бид зөв зохистой амьдрах юм бол айх ямар ч шаардлагагүй гэдгийг онцол. Хүүхдүүдийг энэ талаар гэртээ эцэг эхтэйгээ ярилцахыг урь. “Тэр эргэн ирэхэд” (ХДН, 82–83) дууг дуул.

4 дэх долоо хоног: Би Есүс Христтэй дахин амьдарч чадна

Ойлголтыг чухалчил: Хүүхдийн хэсэг эхлэхээс өмнө дараах үгсийг бичсэн гишгэж явахаар нь, цаасаар хайчилсан чулуунуудыг хүүхдийн сандал доор тогтооно: баптисм, гишүүний баталгаа, залбирал, гэр бүлийн үдэш, ариун ёслолоос хүртэх, сүмдээ явах болон ариун сүмийн гэрлэлт. Дэлхийн зургийг өрөөний нэг буланд тавиад Есүс Христийн зургийг нөгөө буланд тавь. Нэг хүүхдийг дэлхийн зургаас Есүсийн зураг руу нэг үсрээд л очихыг хүс. Есүс болон Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин хамт амьдрахын тулд алхах ёстой алхмууд байдаг гэдгийг хүүхдүүдэд тайлбарлан хэл. Хүүхдүүдийг сандал доор нь алхаж явах чулуунууд байгаа эсэхийг шалгахыг хүс. Алхах чулуутай хүүхдүүд нэг нэгээрээ самбарт гарч ирээд чулуун дээр бичигдсэн үйлдлийг амьдралдаа хийснээр энэ нь хэрхэн тэднийг Христэд ойртуулах талаар хэлэхэд урь. Тэгээд чулуугаа хоёр зургийн хооронд газар тавь. Чулуунууд хоёр зургийн хооронд алхах зам үүсгэх хүртэл үргэлжлүүлэн хий. Нэг хүүхдийг дэлхийн зургаас зөвхөн чулуунууд дээр гишгэн Аврагчийн зураг хүртэл алхахыг хүс. Есүс Христтэй дахин хамт амьдрахын тулд энэхүү зам дээр үлдэхийн төлөө үргэлж зөвийг хийж байхыг хүүхдүүдэд чухалчил.

Хэрэгжүүлэлтийг чухалчил: Хүүхдүүдийг хоёр хөлийнхөө хэлбэрийг тус тусад нь цаасан дээр зураад хоёулан дээр нь Есүс Христтэй дахин хамт амьдрахын тулд хийх ёстой нэг нэг зүйл бичихийг хүс. Төгөлдөр хуурчийг “Би Бурханы төлөвлөгөөг дагана” (ХДН, 164–165) дууг тоглох зуур хүүхдүүд

өнгөөр ялган будна. Хүүхдүүдийг зурсан зүйлсээ гэр дүүгээ авч яваад гэр бүлийнхэндээ үзүүлэхийг хүс.




Чулуун шат энд дар.

Зөвлөмж: Бүх насны хүүхдүүдийг хамруулахаар төлөвлө. Жишээлбэл, 3 дахь долоо хоногт хийсэн үйл ажиллагаа нь томхон хүүхдүүдэд илүү тохиромжтой. Бага насны хүүхдүүдэд зориулан тохируулах арга замыг мөн төлөвлө.

Зөвлөмж: Зааж буй хүүхдүүдээ хайрлаж буйгаа харуулахын тулд тэдний хийсэн зүйлст чин сэтгэлийн магтаал хэл. Жишээлбэл, та зүгээр ерөнхий “маш сайн”, эсвэл “баярлалаа” гэж хэлэхийн оронд “Гэр бүлийнхээ түүхээс хуваалцсанд баярлалаа” гэх мэт тодорхой магтаал хэлж байгаарай.

Зорилготой хөдөлгөөнт үйл ажиллагаа

Хүүхдүүд тодорхой зорилготой үйл ажиллагаануудаас их зүйлсийг сурдаг. Энэ үйл ажиллагаанд хүүхдүүд Христэд очихын тулд хийх ёстой зүйлсийг төлөөлсөн алхмуудаар алхсан. Аль болох олон хүүхэд оролцуулахыг хичээ.



Зөвлөмж: Дуу хөгжим нь хүүхдүүдийг тайвшруулж, сонсож мөн суралцахад нь бэлтгэж өгдөг.

Жишээлбэл, та гараа өндөрт өргөөд, дуулж байхдаа таны гар уруу харж бай гэж хүүхдүүдэд хэл. Гараа буулгах тусам нь тэд илүү намуухан, удаан дуулах хэрэгтэйг сануул. Тэдний хүндэтгэлтэй байдалд нь талархлаа илэрхийл.

Зөвлөмж: Хүүхдийн хэсэгт үр дүнтэй бөгөөд хөгжилтэй дуулах цагийг бий болгохын тулд та чадварлаг хөгжимчин эсвэл сайхан дуулдаг байх шаардлагагүй.

Хүүхдийн хэсэгт дуу хөгжмийг хэрхэн ашиглах тухай

Хүүхдийн хэсэгт дуу хөгжим ашиглахын гол зорилго нь Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүдэд заах явдал юм. Хүүхдийн хэсгийн дуунууд нь сайн мэдээг сурах үйл явцыг таатай болгож, Сүнсийг урьж, хүндэтгэлтэй, суралцах уур амьсгалыг бий болгодог.

Хичээлээ эхлүүлэхээс өмнө удиртгал хөгжим тоглуулах нь Сүнсийг урьж хүндэтгэлтэй байдлыг бий болгодог

Удиртгал хөгжим нь хүндэтгэлтэй уур амьсгалыг бий болгосноор хүүхдүүдийг сайн мэдээнээс суралцахад бэлтгэдэг. Хүүхдүүдийг ангидаа орж ирэх үед хөгжим тоглох нь зүйтэй.

Бусад хүүхдүүдийг ангид орж ирсээр л байх үед орж ирсэн хүүхдүүд нь хөгжимтэй хамт даган дуулахыг урьж болно. Жишээлбэл, та гараа дэлгэж харуулбал хүүхдүүд дуулж,

харин гараа буулгасан байхад хүүхдүүд зөвхөн аяыг нь амандаа аялах хэрэгтэй гэдгийг хүүхдүүдэд хэл.

Удиртгал хөгжмийн цагт дуунуудын аяыг дарах нь хүүхдүүдийг тухайн дууны аяыг тогтоож танил болоход нь тусална. Дуугаа сонгоод аяыг нь амаараа аялж сонсо. Тэгээд тантай хамт дууны аяыг аялахад уриарай.



Хүүхдийн ангид орж ирсэн цагаас нь л хүүхдийг дуу хөгжимд татан оролцуулах хэрэгтэй.

Сайн мэдээний зарчмуудыг заахад дуу хөгжмийг ашигла

Тэд зөвхөн дуу сурч байгаа биш сайн мэдээний зарчмуудыг мөн суралцаж байгаа гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. (ХДН, iii). Тэднээс дуунд заагдаж байгаа зарчмуудад анхаарлаа хандуулахад нь туслах үүнээс асуулт асуух юм уу эсвэл сая тухайн нэг үг, хэллэгийг хэдэн удаа дуулснаа тоолох гэх мэт энгийн үйл ажиллагаа явуулах нь

зүйтэй (Хоёрдугаар сарын хөгжмийн удирдаачид зориулсан тусламж гэсэн хэсгийг үз).

Хүүхдүүд дуулах үедээ гэрчилдэг (Нэгдүгээр сар, 1 дэх долоо хоногийг үз). Хүүхдүүдийн өмнө эгц суугаад хамгийн сайнаараа гоё хоолойгоор дуулахыг хүс. Тэднийг сайн дуулах үед нь талархаж, магтаалын үг хэл.



Гэртээ дуугаа давтах

Дууг үр дүнтэй сайн заахын тулд та өөрөө дуугаа сайн мэддэг байх ёстой. Гэртээ дуугаа давтаж бэлтгэл хийснээр та хүүхдүүдийн өмнө гараад ном руу биш тэдэн рүү харж зааж чадна.

Дуу заах миний төлөвлөгөө

Дуугаа мэддэг байх: давт, давт, давт

Өөрөөсөө дараах асуултуудыг асуу:

1. Хүүхдүүдийн анхаарлыг би хэрхэн татах вэ?
2. Дуунд агуулагдах сайн мэдээний утга санааг ойлгоход нь туслах ямар асуултыг би хүүхдүүдээс асуух вэ?
3. Тэднийг хүчирхэгжүүлэх ямар гэрчлэл тэдэнтэй хуваалцах вэ?

Дууг хэрхэн заах вэ?

Дууг хэрхэн заах арга замаа төлөвлөж байхдаа дараах асуултуудыг өөрөөсөө асуу: Би хүүхдүүдийн анхаарлыг хэрхэн татах вэ? Энэ дуун дахь сайн мэдээний зарчмыг ойлгоход нь хүүхдүүдэд туслахын тулд би ямар асуулт асуух вэ? Тэднийг хүчирхэгжүүлэх ямар гэрчлэлийг би тэдэнд хуваалцах хэрэгтэй вэ? (ХДН, 300-г үз)

Шинээр дуу сурахдаа дууны үгийг дангаар нь бүү давтан хэл. Үүний оронд дуулах хэрэгтэй. Энэ нь хүүхдүүдэд аяаг үгтэй нь холбогдуулан санахад нь тусална. Хүүхдүүд дууг дахин

дахин сонсож мөн дуулснаар сурдаг билээ. Дуу сурахын тулд хүүхдүүд унших шаардлагагүй. Жишээлбэл, та хүүхдүүдийг таны цуурай болохыг хүсэж болно. Таныг дуулж байх зуур хэлэгдэх богино хэллэг буюу мөрийг сайн сонсохыг хүүхдүүдээс хүс. Та чихэндээ гараа барь. Тэгээд таны дуулсан хэсгийг эргүүлэн хүүхдүүд дуулах ээлж ирэх үед тэдэнд дохио өг. Хоёр мөрийг энэ маягаар дуулаад, хүүхдүүдийг суртал нь давтан дуул. Тэд дууг бүгнээр нь суртал дараагийнх нь хоёр мөрийг мөн үүнчлэн дуул (тэгээд дараагийн хоёр гэх мэтчилэн дуусга).

Дууг сурахын тулд болон хөгжилтэй байх үүднээс дахин дуулж болно

Давтах дуугаа сонгохдоо хүүхдүүдийг оролцуул. Жишээлбэл, хүүхэд бүрд зүрх хэлбэртэй хайчилсан цаас өгөөд дээр нь нэр, дуртай дуугаа бичихийг хүс. “Зүрх сэтгэлийн дуунууд” гэж хаягласан саванд зүрхнүүдийг хийгээд, хүүхдүүдийг цөөн хэдэн

зүрх гаргаж ирэн дуулах дуугаа сонгохыг хүс. Хүүхдийн хэсгийн дуунууд нь тайвширал, удирдамж болон сүнслэг өдөөлтийн эх үүсвэр бөгөөд бид дуунуудыг бараг л ямар ч цаг үед, хаана ч дуулах боломжтой.

Хүүхдүүдийн оролцоог сайжруулж, зохих үйл хөдлөлийг хийлгэх үүднээс дуу хөгжмийг ашиглаж болно

Дууг үйл хөдлөлтэйгөөр дуулах нь хүүхдүүдэд дууг илүү хурдан сурахад нь тусална. Энэ нь мөн тэдний анхаарлыг төвлөрүүлж чаддаг. Ариун, хүндэтгэлтэй дуунуудын үйл хөдлөл нь зохистой байх хэрэгтэй гэдгийг үргэлж санаарай. Гараараа хийх энгийн жижиг хөдөлгөөнүүд нь бараг бүх дуунд зохимжтой (нэгдүгээр сарын дууны удирдаачдад зориулсан тусламжийг үз). Жишээлбэл, “Би Аврагчийнхаа хайрыг мэдэрдэг” (ХДН, 74–75) дууг дуулж байхдаа хайр гэдэг үгийг дуулах бүртээ зүрхэн дээрээ гараа тавихыг хүүхдүүдээс хүс. Хөгжилтэй үйл ажиллагааны нэлээн хэдэн дуунууд *Хүүхдийн дууны номонд байдаг.*

Тэдгээр дуунуудыг ашигласнаар хүүхдүүд ч мөн хөгжилтэй сайхан байх болно. Жишээлбэл:

- “Толгой, Мөр, Өвдөг, Хөл” (ХДН, 275) дууг хүүхдүүдтэй хамт эхний удаад жирийн хурдтай дуулаад, аажим аажмаар хурдасч, тэднийг таньтай зэрэг хурдалж чадах эсэхийг нь шалга.
- “Тэд намайг номлолд дуудна гэж найдаж байна” (ХДН, 169) дууг дуул. Бага насны хүүхдүүдийг Мормоны Ном барин, морь унаад хол амьдардаг хүмүүс рүү явж байгаа мэтээр үйлдэл хийхийг хүс. (Тэд мөн онгоцоор нисэж байгаа юмуу донсолгоотой вагоноор явж байгаа мэт дүрсэлж болно.)



Зөвлөмж: Дуу хөгжмийг үр дүнтэй ашигласнаар Сүнсийг урьдаг. Дууг дуулж дуусаад, тэд хайр ба амар тайвныг мэдэрснээр Ариун Сүнс үнэнийг танихад нь тусалдаг гэдгийг хэл.

Аврагч надад хайртайг мэднэ

Хүндэтгэлтэйгээр ♩ = 120-132

Үг, ая Тами Жепсон Кример, Дирина Белл

1. О - лон жил-ийн өм - нө үзэс
2. О - доо би нэ - гэн үзэс

гэ-лэнт га - зарт Е - сүс-ийг хүүх - дүүд той - рон суу-гаад
гэ-лэнт га - зарт Е - сүс-ийн заа - сан сур - гаал-ыг су - рна

Тэд хайр-ыг мэд - рэ - хэд зааж а - дис - лав. Бүгд Түү - ний нулим - сыг ха
Э - цэг эх, багш нар - ын уд - ир - дам - жаар, Өдөр бүр зөв зам - аар алх

рав. _____ Хүүх - дийн тө - лөө гэ - сэн хайр - ыг Тэр мэд - рэв.
на. _____ Ав - рагч - ийн хайр - ын му - тарт тэ - вэр - үү - лэхэд,

Ми - ний тө - лөө байс - ныг нь мэд - нэ. Би Түүнд хү - рч ө - вөр
Би зөө - лөн хү - рэх - ийг мэ - дэр - дэг. Ө - дөр бүр амьд - рал - даа

дээр суу - гаа - гүй ч Е - сүс үнэ - хээр бай - даг. Тэр амьд
 Э - цэг - ийн гэр уруу Хөг - лөх зам - ыг да - гана.

ыг би мэд - нэ! Би түү - нийг ит - гэ - лээр

да - гах бол - но. Би зүрх сэт - гэ

лээ өг - нө. Ав - рагч на - дад хайр - тайг мэд - нэ.

Ав - рагч на - дад хайр - тайг мэд - нэ.



ЕСУС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэв

© 2009, 2014 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 5/14. Орчуулгын зөвшөөрөл: 5/14. 2015 Outline for Sharing Time and the Children's Sacrament Meeting Presentation-ын орчуулга. Mongolian. 13483 363

Image credits: Нүүрний хавтас: Төгс хайр, Дел Парсоны бүтээл © Del Parson. Хуудас 3: Иохан Баптист Есүст баптисм хүртээж байгаа нь, Харри Андерсоны бүтээл, © IRI; Христ ба Мормоны Номын хүүхдүүд, Дел Парсоны бүтээл, © 1995 Del Parson; Анхны Үзэгдэл, Гари Каппын бүтээл, © Gary Kapp—хуулбарлахыг хориглоно. Хуудас 9: Миний зүрх сэтгэлийн хүслэн, Уолтер Рэйний бүтээл, Сүмийн түүхийн музейн зөвшөөрлөөр нийтлэв. Хуудас 14: Есүс хараагүй хүнийг эдгээж байгаа нь, Карл Хейнрик Блок, Данийн Хиллрод хотын Фредериксборгийн үндэсний түүхийн музейн зөвшөөрлөөр нийтлэв. Хуудас 15: Иохан Баптист Есүст баптисм хүртээсэн нь, Харри Андерсоны бүтээл, © IRI; Тиймээс та нар явагтун, Харри Андерсоны бүтээл, © IRI. Хуудас 17: Есүс Жайруссын охиныг адисалж байгаа нь, Грег К.Оулсены бүтээл, © 1990. Арын хавтсанд: Түүний нөмөр дор, Жэй Браинт Вордын бүтээл, © 2004 Jay Bryant Ward.

MONGOLIAN



13483 363